



# МОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2018 • IX • № 23

Н.БАЯРТСАЙХАН:  
СОРИЛТЫН ҮЕД  
ЭДИЙН ЗАСГИЙН  
ТЭНЦВЭР ЧУХАЛ

САНХҮҮГИЙН  
ХЯМРАЛААР ЮУ  
ӨӨРЧЛӨГДӨВ

АСУУДЛЫН ГОЛ  
НЬ ХОЁР УЛС  
ХУДАЛДААНЫ  
БОДЛОГОО  
ХЭЛЭЛЦЭЖ  
ТОХИРОЛЦОХ  
НЬ ЧУХАЛ

МОНГОЛ УЛСЫН ЭРДЭНЭСИЙН САНГААС: ДӨРВӨН  
ХҮЧТЭН СИЙЛБЭРЛЭСЭН САНГИЙН БОЙГОР





## МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ МЭДЭГДЭЛ

Огноо: 2018/09/20

**Бодлогын хүүг хэвээр хадгалах тухай**

**Дугаар: 2018/03**

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 2018 оны 9 дүгээр сарын 20-нд хуралдаж, Бодлогын хүүг 10 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргалаа.

Хэрэглээний үнийн индексээр хэмжигдсэн жилийн инфляци 2018 оны 8 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд 6.0 хувь, Улаанбаатар хотод 6.4 хувьд хүрээд байна. Инфляци дунд хугацаанд төв банкны зорилтот 8 хувийн орчимд тогтворжих төлөвтэй байна. Нийлүүлэлтийн шинжтэй инфляцийн дарамт буурахаар байгаа ч эдийн засгийн идэвхжилтийг даган эрэлтийн гаралтай инфляци алгуур сэргэж байна.

Олон улсын зах зээл дээрх эрдэс бүтээгдэхүүний үнэ харьцангуй өндөр түвшинд хадгалагдсанаар уул уурхайн бүтээгдэхүүний экспорт нэмэгдэж, эдийн засгийн сэргэлтийг даган хөрөнгө оруулалт тэлж, улмаар эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлж байна. Эдийн засгийн эрчимтэй өсөлтийг харгалзан Монголбанк 2018 оны өсөлтийн таамаглалаа нэмэгдүүлсэн хэдий ч эдийн засгийн төлөв байдал гадаад эдийн засгийн орчноос өндөр хамааралтай хэвээр байна. Тухайлбал, том гүрнүүдийн хоорондох гадаад худалдааны хязгаарлалтын бодлогууд, зарим улс оронд хэрэгжүүлж буй олон улсын хориг арга хэмжээ, түүнийг дагасан эрдэс бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт, хөгжиж буй орнуудаас гадагшилж буй хөрөнгийн урсгал, ам.долларын ханш бусад валютын эсрэг чангарч буй хандлага, манай улсын импортын хэмжээ өндөр байгаа зэрэгтэй холбоотойгоор төгрөгийн ханш сүүлийн улиралд суларлаа. Гадаад орчны тодорхой бус байдал нэмэгдэж буй үед зах зээлд оролцогчдын санхүүгийн эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх, эдийн засгийн гадаад болон дотоод тэнцвэртэй байдлыг хангах нь дунд, урт хугацааны тогтвортой байдалд чухал болоод байна.

Монголбанкны бодлогын хүүг хэвээр хадгалах энэ удаагийн шийдвэр нь инфляцийг дунд хугацаанд зорилтот түвшний орчимд тогтворжуулах зорилготой нийцтэй бөгөөд эдийн засаг, бизнесийн идэвхжилтийг дэмжинэ.

Гэхдээ, Мөнгөний бодлогын хороо нь гадаад секторын нөлөөгөөр эдийн засагт үүсч болзошгүй эрсдэл, түүний цаашдын төлөв, дотоодын санхүүгийн зах зээлд үзүүлэх нөлөөг харгалзан үзэж, бодлогын хүүг өсгөх, макро зохистой бодлогын хязгаарлалтыг зөрчсөн тохиолдолд авах арга хэмжээний асуудлыг дараагийн хуралдаанаар хэлэлцэнэ.

Зээл хурдацтай өсч, өрхийн өр, импортыг нэмэгдүүлж, санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй тул макро зохистой бодлогын хүрээнд ипотекийн бус иргэдийн хэрэглээний зээлийн хугацааг 30 сараас хэтрүүлэхгүй байхаар тогтоож, 2019 оны 1 сарын 1-нээс мөрдүүлэхээр тогтлоо.

Гадаад валютын орлогогүй, валютын ханшийн эрсдэлийг удирдах бололцоо хязгаарлагдмал иргэн, ААН, байгууллагад гадаад валютын зээл олгох нь эдгээр харилцагчдын өрийн дарамтыг нэмэгдүүлээд зогсохгүй, санхүүгийн систем болон эдийн засгийн эмзэг байдлыг нэмэгдүүлнэ. Иймд санхүүгийн системийн тогтвортой байдлыг хамгаалах үүднээс иргэд, ААН-д олгосон ханшийн эрсдэлтэй валютын зээлийн эрсдэлийн жинг 150% болгон нэмэгдүүлж, 2019 оны 1 сарын 1-нээс мөрдүүлэхээр тогтлоо.

Хорооны хуралдааны хураангуй тэмдэглэлийг хоёр долоо хоногийн дараа Монголбанкны цахим хуудаст байршуулна.

**МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРОО**



Монголбанкны Олон нийтийн боловсрол, мэдээллийн төвөөс эрхлэн гаргав.

**Онцлох үйл явдал**

ХУУДАС

4

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг УИХ-д өргөн барив

**Ярилцлага:**

ХУУДАС

7

Н.Баяртсайхан: Сорилтын үед эдийн засгийн тэнцвэр чухал

**Байр суурь:**

ХУУДАС

12

Төрийн мөнгөний бодлогын 2018 оны хэрэгжилтийн талаар хэн юу хэлэв?

**Нийтлэл:**

ХУУДАС

14

Чанартай институци ба хүчтэй хэрэгсэл

**Улаанбаатарын зөвшилцөл:**

ХУУДАС

18

Дэлхийн болон том төсөл хөтөлбөрүүдэд багтаж орох, газар нутгийн байршлын давуу талаа ашиглах нь

**Эрдэнэсийн сан:**

ХУУДАС

20

Дөрвөн хүчтэн сийлбэрлэсэн сангийн бойпор

**Асуулт, хариулт:**

ХУУДАС

22

Ипотекоос бусад хэрэглээний зээлийн хугацааг 30 сар хүртэл хязгаарласан

**Судалгаа:**

ХУУДАС

31

Зээлийн хүүг бууруулах стратегийн тойм

**Банкир:**

ХУУДАС

33

Асуудлын гол нь хоёр улс худалдааны бодлогоо хэлэлцэж тохиролцох нь чухал

**Дэлхийн үйл явдал:**

ХУУДАС

37

Санхүүгийн хямралаар юу өөрчлөгдөв?

**Санхүүгийн боловсрол:**

ХУУДАС

41

Валютын ханш хэрхэн тогтдог вэ?

## Дурсгалын зоосны цувралыг “Олон улсын хамтын ажиллагаа” сэдвээр баяжуулаа

2018.09.05

Энэ онд манай улсын гадаад хамтын харилцааны түүхэн ойнууд тохиохтой холбогдуулж, Монгол Улсын дипломат харилцаа тогтоосон ОХУ, БНХАУ, Япон Улс, БНСУ зэрэг улсын хамтын ажиллагааг харуулсан тэгш өнцөгт хэлбэртэй 32 гр бүхий цэвэр мөнгөн зоос худалдаанд гарлаа. Ирэх сард “Монгол Улсын олимпын медальт тамирчид” цувралын үргэлжлэл болж 1968 оны Мехикогийн Зуны XIX олимпоос мөнгө, хүрэл медаль хүртсэн Ж.Мөнхбат, Д.Сэрээтэр, Ч.Дамдиншарав, Т.Артаг нарын түүхэн амжилтын 50 жилийн ойд зориулсан дурсгалын зоосыг худалдаанд гаргах юм. Мөн зоосны худалдаатай дэлгэрэнгүй танилцах [coin.mongolbank.mn](http://coin.mongolbank.mn) цахим хуудсыг энэ сард нээлээ.



## Зүүн бүсийн банкны салбарын ажилтны зөвлөгөөн Хэнтий аймагт болов

2018.09.14



Банкны салбарын удирдах ажилтны бүсийн зөвлөгөөн хоёр дахь жилдээ болж, зүүн болон говийн бүсийн Монголбанкны хэлтэс, салбар, арилжааны банкууд оролцлоо. Зөвлөгөөнд урилгаар Олон Улсын Валютын Сангийн Монгол дахь суурин төлөөлөгч Нейл Сакер оролцож, ОУВС-аас Монгол Улсад хэрэгжүүлж буй хөтөлбөрийн тухай дэлгэрэнгүй танилцуулсан юм. Энэхүү зөвлөгөөнөөр салбарын цаг үеийн бодлогын шийдвэрийг танилцуулах, хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөх, хэрэгжилтийн явцад болон бусад тулгарч буй асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэдэг бөгөөд мэргэжилтнүүдийг давтан мэргэшүүлэх, цаг үеийн мэдээллээр хангах зэрэг сургалт уулзалтыг зохион байгуулдаг уламжлалтай.

## Банкуудад санхүүгийн тайлагналын 9-р стандартыг нэвтрүүлнэ

2018.09.18

Монголбанкнаас банкны салбарт Санхүүгийн тайлагналын олон улсын 9 дүгээр стандартыг 2020 онд нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна. Үүнтэй холбогдуулан хэрэгжилтийг хангаж ажиллах байгууллагуудыг оролцуулсан хэлэлцүүлгийг зохион байгуулсан юм. Энэ үеэр “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах үндсэн чиглэл”-ийн төсөл боловсруулах ажлын хүрээнд “Нягтлан бодох бүртгэлийн багц материал”-д өөрчлөлт оруулах, стандартыг банкуудад мөрдүүлэх бэлтгэл ажлыг хангуулах, стандартыг мөрдүүлэхэд учирч болзошгүй хүндрэл бэрхшээлийн талаар санал солилцов. Мөн цаашид энэ чиглэлээрх хамтын ажиллагааг эрчимжүүлэхээр тогтлоо.



## Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг УИХ-д өргөн барив

2018.09.25



2019 онд баримтлах мөнгөний бодлогын үндсэн чиглэлд эдийн засгийн эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх замаар эдийн засагт ажиглагдаж буй сэргэлтийг бэхжүүлж, хүртээмжийг нь нэмэгдүүлэхэд анхаарав. Мөн мэдээллийн технологийн болон тогтвортой санхүүжилтийн сайн туршлагыг нэвтрүүлэх, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зорилтыг амжилттай хэрэгжүүлснээр санхүүгийн зах зээлийн хөгжлийг гүнзгийрүүлэхийн зэрэгцээ эдийн засгийн өсөлтийн үр өгөөжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ хэмээн үзэж бодлогын зорилтуудыг тусгаад байна. Энэ оны эхний хагас жилийн байдлаар эдийн засгийн өсөлт эрчимжин 6.3 хувьд хүрч, ажил эрхлэлт 3.1 хувиар өссөнөөр инфляци алгуур сэргэж байгаа ч Монголбанкны 2018-2020 оны инфляцийн зорилтод түвшинд буюу 8 хувьд хэвээр хадгалагдах юм.

## Мэргэшсэн Нягтлан бодогчдын Институттэй хамтарч ажиллана

2018.09.27

Монголбанк болон Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт нь "Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр"-ийн хүрээнд жижиг дунд аж ахуйн нэгж, бичил бизнес эрхлэгчдийн бүртгэл, тайлагналын чанарыг сайжруулах, салбарын мэргэжилтний чадварыг тасралтгүй хөгжүүлэх, мэргэшүүлэхэд хамтран ажиллахаар болж "Хамтын ажиллагааны санамж бичиг" байгууллаа. Санамж бичиг байгуулах ёслолд Монголбанкны Дэд Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн Мэргэшсэн нягтлан бодогчдын институтцийн захирал Г.Энх-Амгалан нар оролцож, санамж бичигт гарын үсэг зурлаа.



## Үндэсний төлбөрийн системд цахим мөнгийг нэвтрүүлээ

2018.09.28



Монголбанк Монгол Улсын мөнгөн тэмдэгт - төгрөгтэй адилтгах үнэ цэнэ бүхий бэлэн бус төлбөрийн хэрэгслээр тооцогдох Candy "Цахим мөнгө гаргах" тусгай зөвшөөрлийн гэрчилгээг "Мобифинанс" ББСБ-д олголоо. "Candy" нь анх зөвхөн Мобикомын хэрэглэгчдэд зориулагдан бүтээгдсэн урамшуулал олгох лоялти хөтөлбөр байсан бол өдгөө Монгол орон даяар аль ч операторын хэрэглэгч ашиглах боломжтой цахим мөнгө болж байгаа бөгөөд Үндэсний төлбөрийн системд Монголбанкаар баталгаажсан цоо шинэ төлбөрийн хэрэгсэл болж байна.



## “Монгол Улсын гадаад худалдааны бодлогод анхаарах асуудлууд” хэлэлцүүлэг хийв

2018.09.28

Монголбанкнаас санаачлан “Монгол Улсын гадаад худалдааны бодлогод анхаарах асуудлууд” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулж, энэ үеэр “Монгол Улсын гадаад худалдааны бодлогод анхаарах асуудлууд”, “Экспортыг дэмжих урамшуулах ба худалдааг хөнгөвчлөх асуудлууд” илтгэлийг хэлэлцүүлээ. Монгол Улс өнөөдрийг хүртэл гадаад худалдааг тусгайлан хариуцсан төрийн байгууллага, яам, агентлаггүй, гадаад худалдааны цогц бодлогогүй явж ирснийг шүүмжлэв. Мөн гадаад худалдааны асуудлыг тусгайлан авч үзэж, ач холбогдол өгснөөр төлбөрийн тэнцлийн алдагдлыг бууруулах, гадаад валютын нөөц нэмэгдэх, эдийн засгийн бүтцийг өөрчлөх ач холбогдолтой гэж үзэж байв. Хэлэлцүүлгийн үеэр гарсан санал, дүгнэлтүүдийг нэгтгэн бодлогын зөвлөмж гаргана.



## Ипотекийн зээлийн санхүүжилтэд 16 тэрбум төгрөг олгов

2018.10.02



Монголбанк 2018 оны есдүгээр сард ипотекийн зээлд зориулж 16 тэрбум төгрөгийн санхүүжилтийг банкуудад олгож, 239 иргэн шинээр ипотекийн зээлд хамрагдлаа. Энэ оны эхний 9 сарын байдлаар Монголбанкны эх үүсвэрээс 143.7 тэрбум төгрөг, Засгийн газрын эх үүсвэрээс 59.6 тэрбум төгрөг, нийт 203.2 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг 2,963 иргэнд олгоод байна.



## Н.БАЯРТСАЙХАН: СОРИЛТЫН ҮЕД ЭДИЙН ЗАСГИЙН ТЭНЦВЭР ЧУХАЛ

Төв банк жил бүр УИХ-ын намрын чуулганы эхэнд ирэх ондоо баримтлах мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн төслийг өргөн барьдаг. Өнгөрч буй нэг жилийн хугацааны мөнгөний бодлогын хэрэгжилт, эдийн засгийн цаашдын төлөв болон 2019 онд авч явуулах үйл ажиллагааны талаар Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайханаас тодруулан ярилцлаа.

**ДЭЛХИЙН ТОМООХОН  
УЛС ГҮРЭН ХООРОНДОХ  
ХУДАЛДААНЫ ЗӨРЧИЛ  
МАРГААН, ДЭЛХИЙН ЗАХ  
ЗЭЭЛ ДЭХ ЗЭСИЙН ҮНИЙН  
УНАЛТ, НЕФТИЙН ҮНИЙН  
ӨСӨЛТ ГЭЭД ГАДААД  
ОРЧИНД НӨХЦӨЛ БАЙДАЛ  
СӨРӨГ ХАНДЛАГААР  
ХУРДТАЙ ӨӨРЧЛӨГДӨЖ  
БАЙНА. ЯГ НЭГ ЖИЛИЙН  
ӨМНӨ ТА СЭРГЭЛТ  
АЖИГЛАГДАЖ БУЙ ТААТАЙ  
ЦАГ ҮЕД “ЦААШДЫН ӨСӨЛТ  
ХӨГЖЛИЙН СУУРЬ БОЛОХ  
БОДЛОГЫН РЕФОРМУУДАА  
ХИЙХ ЦАГ” ГЭЖ МЭДЭГДЭЖ  
БАЙСАН. БИД ОДОО  
СОРИЛТОД ХЭР БЭЛЭН  
БОЛСОН БЭ?**

Монголбанк энэ нэг жилийн хугацаанд санхүүгийнхээ

тогтолцооны дархлааг сайжруулах реформуудыг хийх, валютынхаа нөөцийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ бодит эдийн засгийн сэргэлтийг дэмжих, тогтвортой байдлыг хангахад бодлогоо чиглүүлсэн. Үр дүнд нь олон зэрэг өөрчлөлт гарч байгаа хэдий ч, одоо нөхцөл байдал биднийг илүү хурдтай бөгөөд шургуу ажиллахыг шаардаж байна. Ер нь аливаа реформ хууль эрх зүйн орчин, дүрэм журмын шинэчлэлээс эхэлдэг. Иймд бид Төв банкны тухай хуулийн шинэчлэлээс эхэлсэн. Шинэ хуулиар Монголбанкны хараат бус байдлыг баталгаажуулж, засаглал, шийдвэр гаргах тогтолцоог сайжруулснаар илүү

хариуцлагатай ажиллах нөхцөл бололцоог дээшлүүлж, санхүүгийн тогтвортой байдлыг хангах макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлтэй болсон. Түүнчлэн Банкны тухай хуулийг дагалдах 30 орчим журам шинэчлэгдэж байна. Арилжааны банкуудад олон улсын стандартаар активын чанарын иж бүрэн үнэлгээ хийж дууссанаар санхүүгийн тогтолцоо илүү дархлаатай байх суурь нь бэхжиж байна гэж ойлгож болно. Одоо банкууд эрсдэлийн сангаа нэмэн байгуулж, өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж байгаа тул эдийн засагт доржилт, чичиргээ үүслээ ч эрсдэл даах чадвар нь өмнөх жилүүдтэй

харьцуулахад нэлээд дээшилсэн. Түүнчлэн, харилцагч, хадгаламж эзэмшигчдийг хамгаалах, санхүүгийн тогтвортой байдлыг хангахын тулд хямралын үеийн төрийн оролцоог илүү тодорхой болгож УИХ-аас “Банкны салбарын тогтвортой байдлын тухай” хууль батлан гаргалаа. Одоо “Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай” хуулийн төслийг боловсруулж байна. Санхүүгийн салбар эрүүл, найдвартай байсан цагт хувийн хэвшлийн санхүүжилтийн нөхцөл бололцоо сайн, Монголын эдийн засаг илүү бат бэх, тулгарах сорилтод бэлэн байна гэсэн үг. Иргэд, компани, аж ахуйн нэгжүүд ч бас дор бүрнээ санхүүгийн сайн менежменттэй байж эрсдэлд бэлтгэлтэй байх нь чухал.

**ХЭДИЙГЭЭР ЭДИЙН ЗАСГИЙН ГАДААД ОРЧИНД “ЦАГ АГААР” МУУДАХ ШИНЖҮҮД ИЛЭРЧ БАЙГАА Ч МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГ 6.4%-ИЙН ӨСӨЛТТЭЙ ЯВНА. ЭДИЙН ЗАСАГ МААНЬ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН УНАЛТЫГ ДАГААД ОГЦОМ УНАХ ЭРСДЭЛ БИЙ ЮУ?**

-Өсөлт хэрхэн бий болсон үйл явцыг зөв тайлбарлаваас илүү тодорхой ойлгогдоно. 2016 онд эдийн засаг царцанги гэж хэлж болох байдалд орж, зээлийн өсөлт, дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий өсөлт, үнийн өсөлт бүгд сөрөг хандлагатай байснаас гадна гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО)-ын орох урсгал бараг хаагдаж, өрхийн болон аж ахуйн нэгжүүдийн орлого хумигдсанаар татварын орлого буурч байсныг

хүмүүс мартаагүй санаж байгаа. Харин 2017 онд уул уурхайн салбар сэргэж экспортын орлого өмнөх жилийнхтэй харьцуулахад 1.3 тэрбум ам.доллараар нэмэгдэхийн зэрэгцээ өмнөх онд 26 сая ам.доллар байсан ГШХО 1.4 тэрбум ам.долларт хүрч өсөн, ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр” хэрэгжиж эхэлснээр 700 гаруй сая ам. долларын санхүүжилт орж ирсэн. Үнэ ханш ч тогтворжиж, эдийн засагт итгэл сэргэж, мөнгөний бодлогыг эдийн засгийг дэмжихэд чиглүүлсний үр дүнд банкны салбарын зээл олголт нэмэгдэн, 2017 онд 1.2 их наяд төгрөгөөр буюу 10% өссөн. Эдгээр санхүүжилт эдийн засагт шингэснээр өсөлт эрчимжиж, боловсруулах үйлдвэрлэл, тээвэр зэрэг зарим салбар эдийн засаг зогсонги байсан өмнөх оны бага сууриас 15-20% эрчимтэй өсч эхэлсэн. Гэхдээ агшилттай салбарууд ч бас байв.

Тэгвэл 2018 оны хувьд өсөлт тогтворжин, тархалт нь ч жигдэрч барилгынхаас бусад салбар өсөлттэй боллоо. Экспорт, ГШХО үргэлжлэн нэмэгдэж, банкны салбарын эх үүсвэр өсөхийн зэрэгцээ эдийн засагт итгэл дээшилсний үр дүнд зээл олголт ч нэмэгдсэнээр мөнгөний нийлүүлэлт 20 орчим хувь өслөө. Хэдийгээр өмнөх зун ган болж, залгаад зуд нүүрлэснээс үүдэлтэйгээр ХАА-н салбарын өсөлт саарсан боловч, Оюу толгойн баяжмал дахь алтны агууламж нэмэгдсэн нөлөөгөөр уул уурхайн салбарын өсөлт эерэг болсон. Боловсруулах болон

худалдаа, тээврийн салбарын хувьд экспорт болон ГШХО-ын идэвхжилийн дам нөлөө, банкны зээлийн өсөлтөөр тэтгэгдэж байна. Бизнесийн үйл ажиллагаа идэвхжиж, салбаруудын өсөлт жигдэрч байгаа нь татварын орлого, тэр дундаа ААНОАТ-ын орлого 30 орчим хувиар өссөнөөс харагдана. Иймд экспортын бүтээгдэхүүний үнэ зарим талаар унаж байгаа хэдий ч, 2019 онд уул уурхайн бус салбарт өсөлт хадгалагдах дүр зурагтай байна. Харин 2020 оноос цааш бизнесээ төлөвлөхдөө гадаад орчны нөлөөг сайтар тооцож үзэх хэрэгтэй байгаа юм.

**МОНГОЛБАНК ЭНЭ ОНД ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БҮЙ ЭЕРЭГ ҮР ДҮНГ БЭХЖҮҮЛЖ, УРТ ХУГАЦААНД ТОГТВОРТОЙ БАЙХ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ ЗОРИЛТ ТАВЬЖ АЖИЛЛАСАН. ЭДИЙН ЗАСГИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ, ТУЛГАРЧ БҮЙ СОРИЛТЫГ ХЭРХЭН ТӨСӨӨЛЖ БАЙГАА ВЭ, ИЙМ ҮЕД ЯМАР БОДЛОГО БАРИМТЛАХЫГ ЧУХАЛД ҮЗЭЖ БАЙНА ВЭ?**

Уул уурхайн бүтээгдэхүүний үнэ буурч, эдийн засгийн нэг гол хөдөлгүүр доголдох байдал мэдрэгдэвч эдийн засгийн сэргэлт инерцид тодорхой хугацаанд хадгалагдах тул тормоз гишгэсэн мэт огцом зогсохгүйг онцлох нь зүйтэй. Эдийн засгийг дэмжих бусад хөдөлгүүр болсон ГШХО болон банкны салбарын зээл нь өсөлтийг санхүүжүүлсээр байх болно. Тухайлбал, энэ онд 50% нэмэгдэж 1.1 тэрбум ам.долларт хүрсэн Оюу толгойн далд уурхайн



хөрөнгө оруулалтын хэмжээ 2019 онд ч энэ түвшиндээ хадгалагдах батлагдсан хуваарьтай. Мөн сүүлийн 2 жилийн бодлогын реформ, эдийн засгийн сэргэлт нь Монгол улсын зээлжих зэрэглэлийг сайжруулах нөлөөтэй байсан бөгөөд Оюу толгойгоос гадна 400 гаруй сая ам.долларын ГШХО 2018 оны эхний 8 сард орж ирсэн байна. Цаашид ч зээлжих зэрэглэлээ дээшлүүлэх, гадны хөрөнгө оруулагчдын итгэлийг алдахгүй байх нь мэдээж чухал. Банкны салбарын хувьд, эрсдэлийн сангуудаа байгуулж, өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх ажил жигдэрснээр зээлийн тасалдал үүсгэхгүй. Засгийн газрын төсвийн төсөлд тусгасан цалингийн өсөлт, хөрөнгө оруулалтын зардлуудын өсөлт нь эдийн засгийг дэмжих нөлөөтэй гэж үзэж байна. Мөн ханшийн өөрчлөлтөөс гадна хэрэглээний зээл болон валютын зээлийн талаар явуулж буй макро зохистой бодлого нь эдийн засгийн дотоод болон гадаад тэнцлийг алдагдуулахгүй байхад түлхэц үзүүлнэ.

Иймд бидний сүүлийн тооцооллоор эдийн засгийн өсөлт 2019 онд 5.0%-8.5% орчимд хадгалагдах төсөөлөлтэй байна. Гэхдээ түүхий эдийн зах зээл тодорхой бус байгаа энэ нөхцөлд өндөр өсөлт гэхээсээ илүүтэйгээр эдийн засаг тэнцвэртэй байж, аливаа гэнэтийн шок чичиргээнд автахгүй байх нь чухал. Ингэснээр тогтвортой өсөлт бий болох, өсөлт ард иргэдийн амьдралд хүртээмжтэй байх нөхцөл бүрдэнэ.

Мөнгөний бодлогын хувьд бодлогын хүүний зээл болон хүүнд нөлөөлөх суваг хүчтэй хэвээр байгаа. Үүн дээр нэмээд макро зохистой бодлогын хэрэгслүүдийг мөнгөний бодлоготой хослуулж хэрэгжүүлж эхэлснээр бодлогын нөлөөллийг дээшлүүлэхийн зэрэгцээ эрсдэлийг хязгаарлах боломжийг нэмэгдүүлж байна. Энэ үед өсөлтийг санхүүжүүлэх нэг гол суваг болох банкны салбарын зээлийг эдийн засгийг тэнцвэртэй байлгахад чиглүүлнэ. Тухайлбал, хэт хурдтай өсч байгаа хэрэглээний зээлийг тогтвортой бөгөөд эрсдэл хуримтлуулахгүй түвшинд хязгаарлан барих, санхүүгийн нөөцийг бизнес эрхлэгч ААН-ууд руу чиглүүлэх бодлогыг баримтална. Энэ нь өрхийн өрийг хэт өндөр түвшинд хүргэхгүй байх, ирээдүйд өсөлт бий болгох бизнесийн хөрөнгө оруулалтыг дэмжих, банкны балансыг илүү эрүүл байлгах, хэрэглээг зохистой байлгах зэрэг давхар олон эерэг нөлөөтэй бөгөөд эдийн засаг тэнцвэртэй байхад чухал юм.

**ЭДИЙН ЗАСАГ 6% ӨСЧ  
БАЙГАА ХЭДИЙ Ч БАРАА  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ ӨССӨӨР  
БАЙНА. ШАТАХУУНЫ  
ҮНЭ ӨСӨХИЙН ЗЭРЭГЦЭЭ  
ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН  
ЦАЛИН НЭМЭГДЭЖ БАЙГАА  
НӨХЦӨЛД ИНФЛЯЦИ  
ТӨВ БАНКНЫ ЗОРИЛТОТ  
ТҮВШИНД ХАДГАЛАГДАЖ  
ЧАДАХ УУ?**

Инфляци өнгөрсөн оны 2-р хагасаас өсч, сүүлийн байдлаар /2018.08 сар/ улсын хэмжээнд 6%, Улаанбаатарт 6.4% байна. Дефляциас гарч, инфляци

**Шинэ хуулиар  
Монголбанкны  
хараат бус  
байдлыг  
баталгаажуулж,  
засаглал, шийдвэр  
гаргах тогтолцоог  
сайжруулснаар  
илүү  
хариуцлагатай  
ажиллах нөхцөл  
бололцоог  
дээшлүүлж,  
санхүүгийн  
тогтвортой  
байдлыг хангах  
макро зохистой  
бодлогыг  
хэрэгжүүлэх үйл  
ажиллагааны  
чиглэлтэй болсон.**

Төв банкны зорилтот түвшинд хадгалагдаж байгаа нь нэг талаас эдийн засаг сэргэж, зогсонги байдлаасаа гарсны илэрхийлэл юм. Харин зарим сард үнийг өдөөж байгаа хүчин зүйлс нь ихэвчлэн цаг агаарын нөлөө, татварын өөрчлөлт, нефтийн үнэ зэрэг нийлүүлэлтийн гаралтай тул мөнгөний бодлогоор хариу үйлдэл үзүүлэх шаардлага бага байв. Төв банкны 8%-ийн инфляцийн зорилт маань бодлогын хүүг бууруулж 10% хүргэж бодит эдийн засгийг дэмжих бололцоог олгосон. Цаашид төрийн албан хаагчын цалин нэмэгдэх боловч ирэх оноос макро зохистой бодлогоор хэрэглээний зээлийн хурдтай өсөлтөд хязгаарлалт тавиад эхлэх тул инфляцид үзүүлэх эрэлт талын дарамт тэнцвэржих болно. Эдийн засагт сэргэлт бий болоод тийм ч урт хугацаа өнгөрөөгүй тул халалтын шинж тэмдэг бага, эрэлтийн гаралтай инфляцийн дарамтыг шингээх орон зай бий бөгөөд Төв банк дунд хугацаанд инфляцийн зорилтот түвшнийг хангахад чиглэсэн бодлого баримтална.

**-АНУ-ЫН ХОЛБООНЫ НӨӨЦИЙН БАНК БОДЛОГЫНХОО ХҮҮГ НЭМЭГДҮҮЛЖ, АМ.ДОЛЛАРЫН ХАНШ ЧАНГАРАХ ХАНДЛАГА ҮРГЭЛЖИЛЖ, ХӨГЖИЖ БУЙ ОРНУУДЫН ВАЛЮТЫН ХАНШ СУЛРАХ ХАНДЛАГА АЖИГЛАГДАЖ БАЙНА. ЭНЭ ҮЕД ТӨГРӨГИЙН ГАДААД ВАЛЮТТАЙ ХАРЬЦАХ ХАНШИЙГ ТОГТВОРТОЙ БАЙЛГАХ ЯМАР АРГА ХЭМЖЭЭ АВАХ ВЭ?**

-Ханшийн өөрчлөлт нь

инфляцид ч, санхүүгийн тогтвортой байдалд ч чухал нөлөөтэй тул огцом савлагаа үүсгэхгүй байх тал дээр Төв банк анхаарч ажилладаг. Харин сүүлийн 2 улиралд ажиглагдсан ам.долларын эсрэг төгрөгийн ханшийн сулралтыг төлбөрийн тэнцэл буюу эдийн засгийн суурь хүчин зүйлстэйгээ нийцтэй хөдөлж байна гэж үзэж байгаа. Төлбөрийн тэнцэл алдагдалтай үед ханшийг тогтмол байлгахыг зорин хүчээр барих гэж оролдох нь алсдаа илүү сөрөг үр дагавартай. 2018 оны хувьд Чингис, Димсам бондын гадаад төлбөр хийгдсэн, мөн эдийн засаг сэргэж байгаатай холбоотойгоор импорт 40 гаруй хувийн өсөлттэй явж ирлээ. Импортыг задалж үзвэл олон жил үйл ажиллагаа нь царцанги байсан ААН-ууд хөдөлж, техникийн шинэчлэл хийж эхэлж буй нь илт мэдрэгдэж байна. Цаашдаа валютын орлого, өсөлтийг бий болгох тоног төхөөрөмж, бүтээн байгуулалтад ашиглах материалууд нь ГШХО-оор санхүүжиж байгаа учир санаа зовоохгүй байгаа. Харин эдийн засаг сэргэхийн хэрээр хэрэглээний импорт 30%-ийн хурдтай нэмэгдэж байгааг интервенци хийж дэмжих нь алсдаа ханш огцом савлах эрсдэлийг хуримтлуулах тул одооноос тогтворжуулах нь зүйтэй.

Ханш уян хатан тогтох нь шокоос хамгаалж, экспортын өрсөлдөх чадварыг дэмжиж, хэрэглээг зах зээл өөрөө үнээр зохицуулж буй нэг хэлбэр шүү дээ. Дэлхийн эдийн засагт тодорхой бус байдал оршиж буй энэ цаг үед

бид валютынхаа байгаа нөөцийг гамнах учиртай. Гэхдээ үүнийг "Төв банк юу ч хийхгүй ажиглаад сууж байна" гэж ойлгож болохгүй. Өмнө хэлсэнчлэн бодлогын хүүний мөнгөний нийлүүлэлтэд үзүүлэх нөлөө сайжирснаас гадна, Монголбанк макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх мандаттай болсон тул ханшийг огцом савлуулахгүй байлгах бололцоо дээшилсэн. Гэхдээ энэ нь шууд илрэн харагдах зүйл биш.

Төгрөг болон валютын эх үүсвэрийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг ялгаатай тогтоосон, валютын зээлийн эрсдэлийн жинг 150% болгож өсгөсөн, хэрэглээний зээл дээр 30 сарын хугацаа болоод 70%-ийн өр орлогын хязгаарлалт хийсэн зэрэг арга хэмжээ нь цаашид ханшийг тогтвортой байлгахад чухал нөлөөтэй. Эдгээр шийдвэр нь иргэд, импортын бизнес эрхлэгчид болон банкуудад шууд хүлээж авахад амаргүй тул 2019 оны эхнээс хэрэгжиж эхлэхээр тодорхой хугацаа өгсөн. Гэхдээ ханшийн огцом дарамт үүсвэл нийт эдийн засагтаа сөргөөр нөлөөлөх тул энэ бол уухаас аргагүй гашуун эм юм.

**-ИРЭХ ОНД МОНГОЛБАНКНЫ ХЭРЭГЖҮҮЛЭХ БОДЛОГО САНХҮҮГИЙН ТОГТОЛЦООНЫ ДАРХЛААГ БЭХЖҮҮЛЭХ, ЦААШИД ЭДИЙН ЗАСГИЙГ ТЭНЦВЭРТЭЙ БАЙЛГАХАД ЧИГЛЭНЭ ГЭЖ ОЙЛГОЛОО. ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БАРИМТ БИЧИГТ ӨӨР ЯМАР ОНЦЛОГ ЗҮЙЛ БАЙНА ВЭ?**

-Төв банкны тухай хуулиар Монголбанкинд ногдуулсан үндсэн зорилтын хүрээнд бид инфляцийг 8%-ийн зорилтот түвшинд хадгалж, санхүүгийнхээ тогтолцоог илүү хүчирхэг болгоход чиглэсэн арга хэмжээнүүдээ авч хэрэгжүүлэх нь бидний үндсэн зорилго. Үүнээс гадна, техник технологийн дэвшил хурдацтай өрнөж, байгаль цаг уурын өөрчлөлтийн асуудлууд ч дэлхий даяар яригдаж буй энэ үед зохицуулагч байгууллагын хувьд зах зээлийн шинэ талбарыг дэмжиж хөгжүүлэх шаардлага тулгарч байна. Иймд энэ удаагийн бодлогын баримт бичигт “Тогтвортой санхүүжилт” болон “Финтек” зэрэг сэдвийг хөндсөн зорилт тусгагдсанаараа шинэлэг болж байна. Бодлогын баримт бичгийг боловсруулах ажлын хэсгийг оны эхэнд байгуулж, энэ сэдвээр олон улсын туршлагыг судлах, дотоодын зах зээлд үйл ажиллагаа явуулж буй энтрепренёр, хөндлөнгийн мэргэжилтнүүдийн дуу хоолой, үзэл бодлыг сонсох уулзалт, хурлуудыг хийсэн. Бодлого боловсруулагч хаалттай, хайрцаглагдсан байж болохгүй бөгөөд Монгол орны төлөө зүрх сэтгэл нь цохилж буй мэдлэг туршлагатай хөндлөнгийн мэргэжилтнүүдийнхээ үгийг сонсох учиртай. Мэдлэг мэргэжилтэй хүмүүс ч өөрсдийн дуу хоолой, мэргэжлийн бодит дүгнэлтээ нийгэмд хүргэх үүрэгтэй. Энэхүү бололцоог бид нээж өгч, бодлогодоо ч тусгаж байна. Үүнээс гадна Монголбанкнаас зохион байгуулдаг онол практикийн хурлуудад оролцох, “Мөнгө санхүү

баялаг” сэтгүүлд судалгааны ажлаа нийтлүүлэх, эсвэл олон нийтэд чиглэсэн “Монголбанкны мэдээлэл” товхимолд ч ярилцлага нийтлэл хэлбэрээр санаа бодлоо хуваалцах боломжтой. Монголын нийгэмд санхүү эдийн засгийн мэдлэг боловсрол дутмаг байгаа асуудлыг шийдвэрлэхэд эдийн засгийн эрдэмтэн судлаач, санхүүгийн салбарын мэргэжилтнүүдийн хувь нэмэр чухал юм. Төв банк бодлого шийдвэрийн хэрэгжилтийн үр дүнгээс гадна олон нийтийн санхүү эдийн засгийн мэдлэгт хувь нэмэр оруулах нь нийгмийн хариуцлагатай байдлын илрэл гэж үзэж байгаа. Иймд “Санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-өө үргэлжлүүлэх, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр олон ажил хийхээр төлөвлөж байна.

**-МОНГОЛБАНК ХЭВЛЭЛ  
МЭДЭЭЛЭЛ БОЛОН ОЛОН  
НИЙТЭД ИЛҮҮ НЭЭЛТТЭЙ  
БОЛСОН НЬ МЭДРЭГДДЭГ.  
2019 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ  
БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ  
ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ  
СУВГАА ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААР  
ЯМАР ЗААЛТ ТУСГАСАН БЭ?**

-Төв банкинд итгэх итгэлийг нэмэгдүүлэх үндэс нь өөрөө нээлттэй ил тод, хариуцлагатай байх бодлого юм. Бидний боловсруулж, хэрэгжүүлж буй бодлого ил тод байснаар эдийн засгийн мэргэжилтэн, судлаач, олон нийтийн зүгээс илүү хяналттай байна гэсэн үг. Хяналттай үед шийдвэр гаргалт ч илүү рациональ байна. Энэхүү эргэх холбоо нь эцсийн дүндээ сайн бодлого шийдвэр болж хэрэгжсэнээр

нийтийн эрх ашигт, нийгмийн сайн сайханд чухал тусгал нөлөөтэй. Иймд олон нийттэй харилцах нээлттэй сувгаа улам сайжруулахад Монголбанк онцгой анхаарч байна, энэ талаар зохион байгуулж хэвшсэн ажлаа цаашид үргэлжлүүлнэ. Инфляцийн тайлан, мөнгөний бодлогын мэдэгдэл зэрэг стандарт хэрэгслүүдээ сайжруулахаас гадна, санхүүгийн салбарын мэргэжилтнүүд төдийгүй олон нийтэд мөнгөний бодлогыг ойлгомжтой тайлбарлах контентууд болон сувгийг хөгжүүлэх ажил хийх болно. Зөвхөн эдийн засагчид, санхүүгийн салбарын мэргэжилтнүүдээс гадна ажил амьдралд нь мөнгөний бодлого нөлөөлдөг иргэд олон нийт, аж ахуйн нэгж компаниуд ч эдийн засгийн нөхцөл байдал, хэрэгжүүлж буй бодлогын зорилт, хүлээгдэж буй үр дүнгийн талаар мэдлэг, мэдээлэлтэй байх нь чухал. Монголчууд ажил амьдралдаа хариуцлагатай санхүүгийн шийдвэр гаргахад суурь нь болох мэдлэг, мэдээллийг Төв банк хуваалцахыг зорьж байна. Эдийн засгийн нөхцөл байдлыг хэрэглэгч, бизнес эрхлэгч, санхүүгийн байгууллага, хууль тогтоогч бүгд өөр өөрийн өнцгөөр харилцан адилгүй хардаг. Уг нь нэг л эдийн засгийн орчинд аж төрж байгаа улс тул та бид бүгд нэг зүг чигт харж, нөхцөл байдлыг бодитой үнэлж цэгнэж, тулгарч болох сорилтыг хамтран даван туулж, эдийн засгийн тогтвортой өсөлт хөгжилд хүрч чадна.

**ТОДОРХОЙ ТАЙЛБАР ӨГСӨН  
ТАНД БАЯРЛАЛАА!**



## ЭНЭ УДААГИЙН ДУГААРТАА ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2018 ОНД БАРИМТАЛСАН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТУХАЙ ОНЦОЛЖ, ҮР ДҮНГ ХӨНДЛӨНГӨӨС ХЭРХЭН ДҮГНЭЖ БҮЙ БАЙР СУУРИЙГ ТОЛИЛУУЛЖ БАЙНА.



ДЭЛХИЙН БАНКНЫ МОНГОЛ  
УЛСЫГ ХАРИУЦСАН ЭДИЙН  
ЗАСАГЧ  
**Ш.АЛТАНЦЭЦЭГ**

Бидэнд долларын ханш хурдтай чангараад байгаа юм шиг санагдавч ч дэлхийн бусад улсуудтай харьцуулахад дотооддоо удирдаж, хяналтдаа авч болохуйц хэмжээнд байгааг хэлье. Хүмүүс төгрөгийн ханшийг хамгаалах талаар Төв банк юу ч хийхгүй байна гэж шүүмжилж байгаа. Юуны тулд Төв банк байдаг вэ гэхээр дунд, урт хугацаандаа ханш инфляцыг тогтвортой байлгахын төлөө бодлого хэрэгжүүлдэг бодлогын институц. Тэрнээс биш өнөөдөр төгрөгийн ханш уналаа гээд улс даяараа хурааж хуримтлуулсан 3 тэрбум доллараа цацаад байвал юу үлдэх билээ. Бид энэ нөөцийг хэрхэн бүсээ чангалж, зардлаа хумьж, төсвийн хатуу бодлого барьж байж хурааж хуримтлуулсан билээ. Уул уурхайн бүтээгдэхүүний үнэ сүүлийн нэг жилд сайн байсан учраас төсвийн орлого өндөр байна. Үүний ачаар төсвийн алдагдлаа бууруулж чадлаа гээд өдөр болгон интервенц хийгээд нөөцөө зараад байх нь зөв үү.

Төв банк шууд утгаар нь интервенц хийж нөөцөөсөө зараагүй ч макро зохистой бодлогыг маш эрчимтэй хэрэгжүүлэх арга хэмжээ авч эхэлсэн гэж бид харж байна. Мөнгөний бодлогын зөвлөл сүүлийн хоёр удаагийн хурлаараа долларын орлогогүй хэрнээ доллараар зээл авч байгаа хувь хүн, аж ахуйн нэгжийг ханшийн эрсдэлээс хамгаалахын тулд энэ төрлийн зээлийг хумих арга хэмжээ авлаа. Хэрэглээний зээл олгох хамгийн урт хугацааг 30 сар болгож богиносголоо. Эдгээр арга хэмжээг 2019 оны нэг сарын нэгнээс хэрэгжүүлнэ. Долларын ханш төгрөгийн эсрэг байж болохуйц хэмжээнээс хэтэрч чангарсан тохиолдолд Мөнгөний бодлогын зөвлөлийг яаралтай хуралдуулж, тодорхой арга хэмжээ авахад бэлэн гэдгээ мөн Төв банк зарласан.



**СУДЛААЧ, ЭДИЙН ЗАСАГЧ  
Б.ОТГОНТӨГС**

Монголбанк инфляцийг зорилтот төвшиндөө барьж чадаж байгаа нь сайн хэрэг. ЗГҮЦ гаргааа зогсоож, ТБҮЦ-ны хугацааг сунгасан нь бодлогын хувьд маш зөв алхам байсан.

Монголбанкны хувьд энэ онд ТМБҮЧ-дээ санхүүгийн боловсролын талаар онцгойлон дурдсан нь маш өндөр ач холбогдолтой юм аа. Иргэдийн санхүүгийн боловсролыг сайжруулах нь төв банкны зүгээс эдийн засгийн хүлээлтийг удирдахад маш чухал ач холбогдолтой.



**ХАСБАНКНЫ  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
М.БОЛД**

Төрөөс 2018 онд хэрэгжүүлсэн мөнгөний бодлого нь макро эдийн засаг, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх, санхүүгийн систем, хууль эрх зүйн орчны шинэчлэлийг үргэлжлүүлэх, эдийн засаг тогтвортой өсөх орчныг мөнгөний бодлогоор дэмжих, олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байгаа дунд хугацаат хөтөлбөрийн тоон болон чанарын зорилтот үзүүлэлтүүдийг улирал бүр хангаж ажиллах чиглэлтэй байсан нь эдийн засгийн өсөлтөд дэмжлэг боллоо. Эдийн засаг 6.3 хувиар өсч, 2016 оны мөн үетэй харьцуулахад экспортоос 1.7 тэрбум ам.долларын, гадаадын шууд хөрөнгө оруулалтаас 1.2 тэрбум ам.долларын нэмүү валют эдийн засагт орж байгаа, валютын нөөц 3 тэрбум ам.долларт хүрсэн, төсвийн орлого давж биелэн тэнцэл нь ашигтай гарч байгаа, активын чанарын үнэлгээгээр банкны систем тогтвортой үнэлгээтэй гарсан гэх мэт эерэг үр дүн бий болов. Цаашид эдийн засгийн гадаад орчин сайжрах, түүхий эдийн үнэ өсөх, ДНБ тэлэх хандлагатай байна. Урьд өмнө ийм таатай

орчинд эдийн засгийн дотоод бүтцээ шинэчлэх тал дээр хугацаа алдсанаасаа сургамж авч 2019 оны мөнгө, төсвийн бодлогод дараах арга хэмжээг авах нь зүйтэй: Зээлийн хүү буурах орчныг цаашид үргэлжлүүлэн дэмжихийн тулд өсөн нэмэгдэж байгаа инфляцийн дарамтыг багасган, ханшийн савлагаа, хэлбэлзлийг бууруулж, хадгаламжийн хүү буурах нөхцөлийг дахин бүрдүүлэх; Төрөөс өрхийг өрийн дарамтад оруулахгүй байх зорилгоор хэрэглээний зээлд шаардлагатай хязгаарлалт, зохицуулалт хийсэн жишгээр бизнесийн, үйлдвэрлэлийн зээлийг дэмжих бодлогын зохицуулалт хийх. Үнийн тогтвортой байдлыг хангах зорилтод харшлахгүйгээр урт хугацааны ажил эрхлэлтийг, шинээр бий болох ажлын байруудыг мөнгө, төсвийн бодлогоор дэмжих нь түүхий эдийн зах зээлээс нэн хамааралтай Монголын эдийн засагт маш чухал байна.

Орон сууцны ипотекийн хөтөлбөрийн санхүүжилтийг одоогийнхоос илүү хялбар, хүртээмжтэй болгох замаар өрхийн орлого импортын хэрэглээнд бус, урт хугацааны хуримтлалд уягдах бодлогыг үргэлжлүүлэх; Гадаад валютын төлбөр тооцоо, клирингийн асуудлаар шийдэл олж, нэмэлт гарцуудыг бий болгох нь санхүүгийн зуучлал, улмаар эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөлнө.



## ЭДИЙН ЗАСАГТ ИТГЭХ ИТГЭЛ: ЧАНАРТАЙ ИНСТИТУЦИ БА ХҮЧТЭЙ ХЭРЭГСЭЛ

**Б.Түмэнцэнгэл** Эдийн засгийн шинжилгээ бодлогын хэлтсийн захирал

Монголын эдийн засаг сүүлийн 20 сар гаруй хугацаанд царцанги байдлаас гарч, хурдтай сэргэж эхэллээ. Үүнийг хэрэглээний болоод хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнүүдийн импортын өсөлт, валютын эрэлт, банкны салбарын зээлийн өсөлт, уул уурхай бус салбарын идэвхжил болон татварын орлогын өсөлт зэрэг олон үзүүлэлтээс харж болно. Гэхдээ макро түвшинд бий болсон эерэг өөрчлөлтүүд цааш хэр удаан үргэлжлэх вэ гэдгээс эдийн засгийн өсөлт хүртээмжтэй байх эсэх нь хамаарна. Өөрөөр хэлбэл, өсөлт тогтвортой үргэлжилж байж сая нэг олон хүний амьдралд хүртээмжтэй болох нөхцөл бүрдэнэ гэсэн үг. Тэгвэл дэлхийн эдийн засагт протекционист бодлого, хориг арга хэмжээ, популист хөдөлгөөнүүдийн сөрөг нөлөө илэрч эхлээд байна. Гадаад орчинд ийнхүү тогтворгүй, тодорхойгүй байдал нэмэгдэж байгаа энэ цаг үед дотооддоо бид юу хийх хэрэгтэй вэ гэдэг асуудал чухлаар тавигдаж байна.

Эдийн засаг бол итгэл дээр тогтдог зүйл. Ирээдүйн талаарх хүлээлт ямар байхаас иргэд, аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн шийдвэр хамаардаг. Зах зээлд оролцогчдын мөнгөтэй холбоотой гаргаж буй шийдвэрүүд нь хэрэглээ, хуримтлал, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл үйлчилгээгээр дамжаад эдийн засгийн идэвхжилд шууд нөлөөтэй. Инфляци, ажилгүйдэл эсхүл ДНБ-ийн өсөлт зэрэг статистик тоон мэдээлэл нь эдийн засагт оролцогчид аль эрт гаргачихсан санхүүгийн шийдвэрүүдийн үр дүнг илэрхийлдэг. Иймд улс оронд үйлдвэрлэл, худалдаа ямархуу байдалтай өрнөснийг харуулах эдгээр тоон мэдээллийг ирээдүйд сайн байлгахын тулд хүмүүсийн итгэл, хүлээлт маш чухал юм. Хүлээлт, итгэл эерэг байх үндэс нь бодлогод итгэх итгэл дээр суурилдаг. Тэгвэл энэхүү хүлээлтийг эерэг байлгахад санхүүгийн салбарт бий болсон дараах 2 өөрчлөлт чухал үүрэг гүйцэтгэнэ.

### ИНСТИТУЦИЙГ БЭХЖҮҮЛЭХ ӨӨРЧЛӨЛТ

Үйлдвэрлэл үйлчилгээний салбарын өрсөлдөх чадвар сул, экспортын бүтэц төрөлжөөгүй тул Монголын эдийн засгийг удирдаж зохицуулах ажил хэзээд амаргүй байсаар ирсэн. Үүн дээр нэмээд засаглал институци хөгжиж бэхжээгүй явдал нь зарим үед бодлогын алдаа гарах нөхцөлийг ч үүсгэж байв. Бодлого тодорхойлогч байгууллагуудын институцийн тогтолцоог бэхжүүлэх нь цаашид оновчтой бодлого хэрэгжиж, эдийн засаг сайн байх нэг чухал тулгуур юм.

2018 оны хувьд Монголын санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд өрнөсөн жил болж байна. Төв банкны тухай хууль, Банкны тухай хууль гээд салбарыг зохицуулах тулгуур хуулиуд шинэчлэгдсэн. Банкуудад олон улсын стандартын дагуу Активын чанарын үнэлгээ хийгдсэн. Мөнгөний бодлогын хороо болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөл ч байгуулагдлаа. Эдгээр нь макро эдийн засгийн бодлого тодорхойлох институцийн хөгжил дэвшилд чухал өөрчлөлт бөгөөд дотор нь салбарын туршлагатай экспертүүд ч карьерийнхаа турш үзээгүй зүйлс цөөнгүй байсан. Залуу мэргэжилтнүүдийн хувьд богино хугацаанд маш их зүйлийг сурч мэдэх боломжийг олгосон сорилттой бөгөөд сонирхолтой цаг үе байсан болов уу. Харин эдгээр нь санхүүгийн салбараас гадуурх олон нийтэд төдийлөн мэдрэгдээгүй эсвэл анзаарагдаагүй том өөрчлөлт байлаа.

Төв банкин дээр хийгдсэн институцийн гол өөрчлөлтүүд дундаас бодлогын шийдвэр гаргах процессийг сайжруулахад чухал үүрэгтэй Мөнгөний бодлогын хороо байгуулагдсанаар бодлогын чухал шийдвэр хамтын зарчмаар гардаг болсныг нэрлэж болох юм. Олон улсын жишгээр эдийн засаг нь амжилттай яваа Төв банкууд чухал шийдвэрээ хамтын зарчмаар гаргадаг бөгөөд ингэснээр олон давуу талуудыг олгодог.

Мэдээлэл цуглуулалт: Олон төрлийн эх үүсвэрээс мэдлэг, мэдээлэл нэг дор цугларах боломжтой



тул илүү мэдээлэлтэй шийдвэр гарах боломжийг нэмэгдүүлдэг. Мөнгөний бодлогын хорооны хурлын үеэр ялгаатай чиглэлээр мэргэшсэн онолын мэдлэг болон практик туршлагатай гишүүд хоорондоо мэдлэг, мэдээллээ хуваалцах нь эдийн засгийн нөхцөл байдлыг илүү олон талаас, бодитоор дүгнэх боломжийг нэмэгдүүлдэг.

Мэдээлэл боловсруулалт: Шинжилгээ, дүгнэлт хийх олон төрлийн арга барилтай гишүүд нэг дор цугларах нь харилцан сул талаа нөхөж, шийдвэр гаргах процессийг илүү үр ашигтай болгох боломжтой тул нэг хүн дангаараа шийдвэр гаргах тохиолдолтой харьцуулахад хамтын шийдвэр давуу талтай гэж үздэг.

Тэнцвэртэй шийдвэр. Олон төрлийн үзэл бодол, харилцан адилгүй өнцгөөс хэлэлцүүлэг өрнүүлж, санал хураалтаар эцсийн шийдвэрийг гаргах нь хэт туйлширсан шийдвэрээс сэргийлэх чухал нөхцөл болдог.

### МАКРО ЗОХИСТОЙ БОДЛОГО

Өсөлтийг бий болгох хөрөнгө оруулалт, мөнгөн эх үүсвэрийг хуваарилдаг санхүүгийн сектор эрүүл бөгөөд найдвартай ажиллах нь аливаа улс орны эдийн засагт маш чухал байдаг. Санхүүжилтгүй үед үйлдвэрлэл үйлчилгээ зогсч, эдийн засгийн өсөлт хөгжлийн талаар ярих аргагүй болно. Харин үйлдвэрлэл болон экспортын төрөлжөөгүй байдал, түүхий эдийн үнээс өндөр хамааралтай эдийн засаг, дотоодын бага хуримтлал, банк давамгайлсан санхүүгийн сектор зэрэг нь манай орны санхүүгийн системийн эмзэг байдлыг нэмэгдүүлдэг хүчин зүйлс юм. Иймд санхүүгийн системийг тогтвортой байлгахын тулд ямар арга хэрэгсэл ашиглах вэ гэдэг чухал асуулт байсаар ирсэн.

Төв банкны шинэчлэгдсэн хуулиар Монголбанк макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх шинэ чиг үүрэгтэй болсон нь энэхүү асуултад чухал хариулт болох болно. Өнөөдөр санхүүгийн болзошгүй хямралаас урьдчилан сэргийлэх, нэгэнт хямрал нүүрлэсэн үед түүний хор хохирлыг бууруулахын тулд макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх нь олон улсад түгээмэл болжээ. Макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэглэснээр бодлогын хүүний нөлөөллийг илүү хүчтэй болгох, мөнгөний бодлогоор удирдах аргагүй эрсдэлүүдийг хязгаарлах зэрэг үр дүн хүлээгддэг. Ингэснээр санхүүгийн системд эрсдэл хуримтлагдахгүй

байх, улмаар эдийн засгийн тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлэх боломжтой.


Мөнгөний бодлого болон макро зохистой бодлогыг хэрхэн үр дүнтэй хослуулан ашиглахыг ойрын ийм нэгэн жишээгээр тайлбарлаж болно. 2016 оны сүүлээс эхлэн хумигдаж байсан банкны зээлийн өсөлт нь 2017 онд 10% орчимд хүрсэн байдаг. Зээл олголт ийнхүү эрчимжсэн нь нэг талаас эдийн засаг идэвхжиж эхэлсний илэрхийлэл байсан бол нөгөө талаас Бодлогын хүүг шат дараатай бууруулсны үр нөлөө юм. Гэхдээ хэрэглээний зээлийн өсөлт зээлийн өсөлтийг дангаараа шахуу бүрдүүлж, харин эдийн засагт чухал үүрэгтэй бизнесийн зээл олголт даруухан байв. Хэрэглээний зээл хэдийгээр худалдаа болон боловсруулах үйлдвэрлэлийн салбарын борлуулалтыг дэмжих эрэлтийг үүсгэдэг ч, энэ тэнцвэргүй байдал удаан үргэлжлэх нь мэдээж эрсдэлтэй. Учир нь өрхийн өр хэт нэмэгдсэнээр зээлээ эргэн төлж чадахгүй болох, хэрэглээгээ хумих зэрэг нь банкны секторт төдийгүй нийт эдийн засагт эрсдэлийг үүсгэж болох юм. Түүнчлэн хэрэглээний зээлийн хэт хурдтай өсөлт нь импортын хэрэглээг өдөөх, улмаар валютын гарах урсгалыг нэмэгдүүлж ханшийн тогтвортой байдалд ч сөрөг нөлөөтэй. Мөн ирээдүйд өсөлт бий болгох хөрөнгө оруулалтууд бус, зөвхөн хэрэглээнд санхүүгийн эх үүсвэрийн дийлэнх нь зарцуулагдах нь тийм ч оновчтой хуваарилалт биш юм. Энэ үед макро зохистой бодлогын арга хэрэгслүүд нь хэрэглээний зээлийг зохистой түвшинд хязгаарлах, бизнесийн зээл олголтыг нэмэгдүүлснээр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих, ханшийн эрсдэлтэй валютын зээлийг хэт нэмэгдүүлэхгүй байх зэрэг нарийн тохиргоог хийх боломжтой юм. Эдгээр нь бодлогын хүү дангаараа үр дүнтэй нөлөөлж чадахгүй эрсдэлүүд бөгөөд, макро зохистой бодлогоор үр дүнтэй удирдах боломжтой.

Сүүлийн нэг жилд Төв банкны Мөнгөний бодлогын хороо буюу шийдвэр гаргах институцийн тогтолцооны шинэчлэл болон мөнгөний бодлоготой хослуулан хэрэглэх макро зохистой бодлого нь хариуцлагатай бөгөөд хүчтэй үр дүнтэй бодлого хэрэгжүүлэх суурийг бүрдүүлэх зүйлс юм. Институцийн чанар болон бодлогын хүчтэй арга хэрэгсэл нь бодлогод итгэх итгэлийг, эдийн засгийн тогтвортой байдалд итгэх итгэлийг дээшлүүлснээр эдийн засагт учирч болзошгүй аливаа сорилтыг амжилттай даван туулах боломжийг нэмэгдүүлдэг.



МОНГОЛБАНК  
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

## Эдийн засаг ба инфляци



## Мөнгөний бодлого 2018 онд

Гуравдугаар улирал

### Мөнгөний бодлогын мэдэгдэл /20.1X.2018/



Бодлогын хүү:


**10% (± 2.0%)**

“Хэрэглээний үнийн индексээр хэмжигдсэн жилийн инфляци 2018 оны 8 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд 6.0 хувь, Улаанбаатар хотод 6.4 хувьд хүрээд байна. Инфляци дунд хугацаанд төв банкны зорилтот 8 хувийн орчимд тогтворжих төлөвтэй байна.”

Нийлүүлэлтийн шинжтэй инфляцийн дарамт буурч байгаа ч эдийн засгийн идэвхжлийг даган эрэлтийн гаралтай инфляци алгуур сэргэж, валютын ханшид богино хугацааны өөрчлөлт үүсч байгааг Төв банкнаас анхааралтай ажиглаж байгаа ба цаашид бодлогын шийдвэртээ тусгах болно.

### Инфляцийн төлөв байдлын тайлан

(2-р улирал)



Оны эцсийн инфляцийн **6.0% - 8.5%** төсөөлөл:

“Цаг агаар, татварын өөрчлөлтийн нөлөөгөөр зарим бүлгийн бүтээгдэхүүний үнэ нэмэгдэж байгаа ч эрэлтээс өндөр хамааралтай бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт бага байв.”

### Инфляцийн гүйцэтгэл



III улиралд инфляци **6.0%** /жилийн/

Монголбанкны бодлогын талаарх мэдээллийг дараах хаягаар авна уу.



[www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn)



@mongolbank.mn



@mongolbank\_mn



mongolbank



11-310119

Н.Батжин

# Хайсан хүлэг Хааны хүрэл 3000



1308-1311 он

Жин

10.45 гр

Голч

3.1 см

Нүүр

“Их төрийн гүйлгээний  
эрдэнэ” гэж дөрвөлжин  
үсгээр бичсэн.

Ар тал

Цулгуй



**Б**оржигин овогт Хайсан 1281 оны цагагчин могой жилийн 8-р сарын 4-нд төрсөн. Дарамбалын (1264–1292) хүү, Чингисийн (1243–1285) ач, Хубилай хааны гуч юм.

305 онд Төмөр хааны хүү Даш таалал төгсөхөд алтан ургийн нэр алдар түгсэн Хайсаныг хаанд өргөмжлөхөөр болж, Хайсан ханхүү дээд нийслэл Шандуд ирж, Их амгалан харшид 1307 оны 5-р сард хаан ширээнд заларчээ.

Хайсан хүлэг хаан буддын шашинд их тус хийсэн бөгөөд бичгийн их хүн Чойжи-Одсэрээр төвөд хэлнээс шашны ном зохиолыг олноор нь монгол хэлнээ хөрвүүлүүлж, уйгуржин монгол бичгийг шинэчлэн засварлаж боловсронгуй болгуулжээ. Хаан бичиг эрдмийг эрхэмлэж, судар ном бүтээх ажлыг хөхүүлэн дэмждэг байв.

Хайсан хүлэг хаан 1311 оны 1-р сарын 27-нд 30 насандаа таалал төгсч, түүнд «Өршөөл өглөг ачлалыг мандуулсан хаан» (Рэньхуй шюаньшяо) хэмээн нэхэн өргөмжилж, «Хүлэг» хаан (Үзун) хэмээн нэхэн цоллосон байна.





*Эдийн засгийн өсөлт,  
санхүүгийн зах  
зээлийн тогтвортой  
байдлыг хангах  
тууштай бодлогын  
төлөө Монголбанкнаас  
санаачлан буй  
"Улаанбаатарын  
зөвшилцөл" баримт  
бичигт тусгасан найман  
зарчмын долоо дахь  
зарчмыг танилцуулж  
байна.*

**ДЭЛХИЙН БОЛОН  
БҮС НУТГИЙН ДЭД  
БҮТЦИЙН ТОМ  
ХӨТӨЛБӨРҮҮДЭД  
БАГТАЖ ОРОХ,  
ГАЗАР НУТГИЙН  
БАЙРШЛЫН ДАВУУ  
ТАЛАА АШИГЛАХ,  
ОРОН НУТГУУД ТЭГШ  
ХӨГЖИХ БОЛОМЖ  
БҮРДҮҮЛЭХИЙН ТҮЛД**



**Д**элхийн болон бүс нутгийн дэд бүтцийн том хөтөлбөрүүдэд багтаж орох, газар нутгийн байршлын давуу талаа ашиглах, орон нутгууд тэгш хөгжих боломж бүрдүүлэх зарчмын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлэх нь үр дүнтэй.

- Олон улсын эдийн засгийн хамтын үйл ажиллагааны байгууллага, хөтөлбөрт нэгдэх;
- Олон улсын байгууллага болон гадаадын урт хугацаат хөнгөлөлттэй зээл, болон бүс нутгийн дэд бүтцийн том хөтөлбөрт багтаж орох;
- Улс орнуудтай эдийн засгийн болон худалдаа, бүс нутгийн түншлэлийн гэрээ байгуулан, хамтран ажиллах;
- Хил залгаа ОХУ, БНХАУ-ыг холбох, цаашилбал, Ази, Европыг холбож болох газар зүйн таатай байршлаа ашиглах;
- Бүс нутаг болон аймгуудыг өөрсдийн давуу тал, онцлогт нь тохирсон бодлого, хөтөлбөрөөр дэмжих замаар орон нутгуудыг тэгш хөгжүүлэх.

Манай улсын хувьд дэлхийн хоёр хүчирхэг улсууд болох ОХУ, БНХАУ-тай хил залган оршдог, уудам цэлгэр тал нутаг, байгалийн арвин их баялаг, нүүдлийн соёл иргэншил зэрэг олон давуу талтай. Дэлхий дахин даяарчлагдахын хэрээр хөгжиж буй улсаас авахуулаад өндөр хөгжилтэй орон хүртэлх дэлхийн бүх улс орнууд дангаар болон ганцаар хөгжиж, оршин тогтнох боломжгүй болсон билээ. Амжилттай хөгжиж буй улсуудын туршлагаас үзэхэд тодорхой ашиг сонирхол, эдийн засаг, газар нутаг, зах зээл, соёл иргэншил, цаг агаарын уур амьсгал зэрэг тодорхой нийтлэг хүчин зүйлсэд тулгуурлан хоорондоо хамтран холбоо нэгдэл байгуулж, нэгдсэн том хөтөлбөр явуулах зэргээр ажлын байрыг бий болгож, эдийн засгаа тэлэн, улс орноо хөгжүүлж байна. Манай улсын хувьд мөн адилаар тодорхой олон улсын холбоо, нэгдлүүдэд нэгдэн орж тодорхой хөнгөлөлт тусламж, ашиг тусыг хүртэж байгаа хэдий ч эдгээр нь хангалтгүй бөгөөд цаашид өөр бусад холбоо, томоохон хөтөлбөрүүдэд элсэн орох, шинээр хамтрал бий болгох шаардлагатай байна.

### Үүнийг хэрэгжүүлэхийн тулд

Эдийн засгийн өсөлтийн нөлөө нь хүн амын бүлгийн дунд тэгш бус байхын зэрэгцээ бүс нутгийн хувьд ч ялгаатай байдаг ажээ. Зарим бүс нутаг, хот илүү хурдан хөгжиж байхад зарим нь хөгжлөөрөө хоцордог. Өөрөөр хэлбэл, хурдацтай хөгжихөд газарзүйн байршил (байгалийн баялагтай эсэх, бизнесийн төвлөрсөн цэг болсон эсэх зэрэг) чухал нөлөөтэй бөгөөд тухайн бүс нутаг руу хүн ам илүү шилжин суурьшдаг байна.

Засгийн газраас хаана хөрөнгө оруулах, дэд бүтэц барьж байгуулахыг шийдвэрлэх замаар боломжийн дахин хуваарилалтыг хийж, илүү тэгш хөгжих боломжийг бүрдүүлэх учиртай. Ялангуяа улс төрийн хувьд энэ эрэлт их өндөр байдаг. Компаниуд хаана салбараа байгуулах нь дэд бүтэц, нийтийн үйлчилгээний хүртээмж, төрийн бодлогоос хамаардаг. Бүс нутгийн бодлогын хувьд харьцангуй сул хөгжилтэй бүс нутагт хөрөнгө оруулалт хийх замаар хувийн хөрөнгө оруулалтыг татаж болно. Түүнчлэн хөдөлмөрийн шилжилт хөдөлгөөнийг дэмжих шаардлагатай. Учир нь буурай хөгжилтэй бүс нутагт хөдөлмөрийн нилүүлэлт эхэндээ илүүдэлтэй байх тул хурдан хөгжиж буй, хөдөлмөрийн эрэлт өндөр бүс нутагт шилжин ажилласнаар нийт бүтээмж, иргэдийн амьжиргаа дээшлэх боломжтой юм.

Түүнчлэн бүс нутгийн хэмжээнд төрөлжилт бий болгох нь давуу талтай. Бүс нутаг бүр өөрийн харьцангуй давуу талд суурилан хоорондоо ялгаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, харилцан нэгнийхээ амжилт, алдаанаас суралцах нь чухал билээ.

Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, бүс нутгийн интеграцчилал болон эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны хөтөлбөрүүд зэрэгт нэгдэн орсноор эдийн засгийн цар хүрээг тэлэх, төрөлжүүлэх боломж бүрдэнэ. Нөгөө талаас дэд бүтцийн хувьд улс дамнасан бүтээн байгуулалтыг хийснээр хязгаар бүсүүдийн эдийн засгийн интеграцчлалыг хангаж, орон нутгууд тэгш хөгжих боломжтой болно.



# МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС

## ДӨРВӨН ХҮЧТЭН СИЙЛБЭРЛЭСЭН САНГИЙН БОЙПОР

ХІХ зууны сүүлч

Далай Чойнхор

вангийн хийц

Жин: 835 гр

Мөнгө цутгамал

Өндөр: 19.5 см, 14 x14 см

Тус бойпорын тагны оройд арслан, таган дээр нь бар, хангарьд, дун толь, бийваа хөгжим зэрэг бурханы шашны таван тахил, бөөрөнд нь ертөнцийн дөрвөн хүчтэний нэг луу болон зээ бадын дүрс чимэглэлтэй. Мөн бойпорыг амнаас нь гал бадарч буй луугаар түшсэн уран нарийн хийцтэй.

Тус бойпор нь Сайн Ноён хан аймгийн Далай Чойнхор вангийн хошууны (одоогийн Хөвсгөл аймгийн Галт сум) харьяат Г.Ерэнтэй дарханы ХІХ зууны сүүл үед урласан мөнгөн бойпорын ган сийлбэрдэх арга, дүрслэл хийцийг дуурайлган хийсэн бүтээл юм. Г.Ерэнтэй дархан нь нутаг хошуундаа төдийгүй монгол даяар цуутай дархан байсан бөгөөд түүний ган сийлбэр бойпор нь Дүрслэх урлагийн музейд хадгалагддаг хосгүй үнэт дурсгал болно.

Ган төмрийг цоолборлон хээний эвэр хажлагыг сөхөн, нэг хээг нөгөөгөөр нь давхцуулан сийлбэрдэх ур хийцийг бусад нутгийн урлалаас ялган, хошуу нутгийн захирагч ноёны нэрээр Далай Чойнхор вангийн хийц хэмээн нэрлэх болжээ.





# МӨНГӨНИЙ БОДЛОГО ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХЖИЛИЙГ ДЭМЖИНЭ

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах үндсэн чиглэлд эдийн засгийн эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх замаар эдийн засагт ажиглагдаж буй сэргэлтийг бэхжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарлаа. Мөн мэдээллийн технологийн болон тогтвортой санхүүжилтийн сайн туршлагыг нэвтрүүлэх, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зорилтыг амжилттай хэрэгжүүлснээр санхүүгийн зах зээлийн хөгжлийг гүнзгийрүүлэхийн зэрэгцээ эдийн засгийн өсөлтийн үр өгөөжийн хүртээмжийг нэмэгдүүлэх болно.

Өнгөрсөн 2 жилд манай улсын гадаад эрэлт өндөр, худалдааны нөхцөл харьцангуй тогтвортой байсны зэрэгцээ уул уурхайн хөрөнгө оруулалт үргэлжлэн тэлж, эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн төсөв, мөнгөний бодлогын хэрэгжилтийн үр дүнд хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдийн итгэл сэргэж бизнесийн орчин алгуур сайжирч байна. Энэ оны эхний хагас жилийн байдлаар эдийн засгийн өсөлт эрчимжин 6.3 хувьд хүрч, ажил эрхлэлт 3.1 хувиар өсөв. Эдийн засгийн өсөлтийг дагаж инфляци алгуур сэргэж байгаа ч Монголбанкны 2018 оны зорилтот түвшинд хадгалагдахаар байна.

Цаашид эдийн засгийн өсөлт, түүний үр өгөөжийг тогтвортой түвшинд хамгаалахад инфляцийн тогтвортой байдлыг хангах,

гадаад валютын нөөцийн хүрэлцээт байдлыг нэмэгдүүлэх, банкны системийн эрсдэл даах чадварыг дээшлүүлэх бодлогыг үргэлжлүүлэх шаардлагатай.

Гадаад эдийн засгийн сөрөг нөлөөг бууруулах, улс орны эдийн засгийн дархлааг сайжруулах, гадаад секторын тэнцвэртэй байдлыг хадгалах, гадаад өрийн эргэн төлөлтийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд гадаад валютын улсын нөөцийг зохистой түвшинд хүргэж нэмэгдүүлэх шаардлагатай. Гадаад валютын орох урсгалын нэмэгдүүлэхэд Монгол Улсад үйлдвэрлэгдэж буй бараа, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах хууль, эрх зүйн таатай орчныг бүрдүүлж, тогтвортой байдлыг хангахад чиглэсэн эдийн засгийн бодлогыг цогцоор нь хэрэгжүүлэх нь нэн чухал болж байна. Иймээс Монголбанк гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх зорилтыг дангаар болон төрийн эрх бүхий байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх байдлаар үндсэн чиглэлд тусгалаа.

Ирэх онд хийгдэх банкны салбарын хууль, эрх зүйн шинэчлэл нь банк санхүүгийн салбарын зохицуулалтыг олон улсын стандартын шаардлага, зарчимд нийцүүлж, мөрдүүлэх, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчинг бүрдүүлэхэд томоохон алхам болно.

Санхүүгийн зах зээлийн дэд бүтэц, институцийг бэхжүүлэх хүрээнд дараах зорилтыг дэвшүүлж байна.

Байгаль орчин, нийгэмд ээлтэй олон улсад мөрдөж буй тогтвортой санхүүжилтийн нийтлэг зарчим, шилдэг туршлагыг санхүүгийн системд нэвтрүүлнэ.

Технологийн дэвшилд тулгуурласан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний зарчим, стандартыг тодорхойлж, мэдээллийн аюулгүй, найдвартай байдлыг хангахад чиглэсэн дэд бүтцийг хөгжүүлж, холбогдох эрх зүйн зохицуулалтыг бий болгож нэвтрүүлнэ.

Чанаргүй активыг бууруулах стратегийн хэрэгжилтийг хангана.

Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн тогтолцоог бий болгоно.

Түүнчлэн санхүүгийн системийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй эрсдэлээс сэргийлэхэд чиглэсэн макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх, банкуудын өөрийн хөрөнгө, төлбөрийн чадварыг сайжруулах арга хэмжээг үргэлжлүүлэх, Төв банкны нээлттэй, ил тод байдлыг хангаж олон нийттэй харилцах харилцааг үр ашигтай болгох зэрэг институцийн хөгжилд чухал ач холбогдолтой зорилтуудыг хэрэгжүүлж ажиллахаар Төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлд тусгаад байна.



## ИПОТЕКЭЭС БУСАД ИРГЭДИЙН ЗЭЭЛД ЭНЭ ШИЙДВЭР ХАМААТАЙ

Монголбанкнаас баталсан шинэ журмын дагуу иргэдийн авах хэрэглээний зээлийн дээд хугацааг 30 сар байхаар тогтоожээ. Энэ журмыг 2019 оны нэгдүгээр сарын 1-нээс мөрдөнө. Иргэдийн хэрэглээний зээлийг яагаад 30 сараар хязгаарлах болсныг Монголбанкны Мөнгөний бодлого, төсөөллийн хэлтсийн захирал Н.Ургамалсүвдаас тодруулсан юм.

### ШИНЭ ЗОХИЦУУЛАЛТЫН ХАМРАХ ХҮРЭЭГ ТАНИЛЦУУЛНА УУ?

Мөнгөний бодлогын хорооноос гаргасан энэхүү шийдвэр нь банкнаас иргэдэд олгох зээлийн хугацааг хамгийн ихдээ 30 сар байхаар тогтоосон. Ипотекээс бусад иргэдийн зээлд энэ шийдвэр хамаатай. Энэ шийдвэр нь Мөнгөний бодлогын хорооны өмнөх хурлаас гаргасан иргэдийн хэрэглээний зээлийн өр орлогын харьцаанд дээд хязгаар тогтоох шийдвэртэй уялдан гарч байгаа шийдвэр юм. Өөрөөр хэлбэл иргэд татварын дараах орлогынхоо хамгийн ихдээ 70 хувийг зээлийн үндсэн болон хүүний төлбөрт төлнө гэсэн үг. Эдгээр шийдвэрүүд нь иргэд

орлогынхоо тодорхой хувийг амьжиргааныхаа наад захын хэрэгцээг хангахад зарцуулах, өрхийн өрийн дарамтыг цаашид нэмэгдүүлэхгүй байх, банкны салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэхэд чухал нөлөөтэйгээс гадна хөрөнгө оруулалт, ажлын байр болон бизнесийн зээлийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд эерэг нөлөөтэй гэж бид харж байгаа. Гэхдээ иргэдийн зээлийн өр, орлогын харьцаанд дээд хязгаар тогтоохдоо зээл олгох дээд хязгаарыг тогтоохгүй бол үр дүн багатай байдаг. Өөрөөр хэлбэл иргэдийн зээлийн хугацааг сунгах замаар өр, орлогын харьцааны дээд хязгаарыг хангах боломжтой юм. Иймээс иргэдэд олгох ипотекеэс бусад

зээлийн хугацааг 30 сараас хэтрүүлэхгүй байх зохицуулалтыг гаргасан. Банкуудын иргэдийн зээлийн дундаж хугацаа 27 сар байна. Тэгэхээр дийлэнх иргэн 30 сараас бага хугацаатай зээлтэй. Цалингийн болон авто машины лизингийн зээлийг урт хугацаагаар авах тохиолдол бий. Тэтгэврийн, малчны зээлүүд хоёр жилээс бага хугацаатай байна. Урт хугацаатай зээл авахын тулд тухайн иргэний ажлын байр төдий хугацаагаар баталгаатай байх ёстой. Гэтэл манай эдийн засаг гадаад сөрөг шоконд 5 жилээс бага хугацаанд өртдөг. Бид уул уурхайгаас ихээхэн хамааралтай. Энэ салбар гадаад зах зээлтэй шууд холбоотой. Эдийн засгийн өсөлтийн дийлэнхийг уул уурхай

болон уул уурхайгаас хамаарал өндөртэй салбарууд хангадаг. Уул уурхайн бүтээгдэхүүний үнэ 4 жилээс бага хугацаанд өсөж, уруудаж байна. Үнийн өөрчөлтийг дагаад компаниуд хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлээ өсгөх, бууруулах шийдвэрээ гаргадаг. Гадаад сөрөг шокийн нөлөөгөөр хувийн сектор үйлдвэрлэлээ бууруулахдаа хамгийн түрүүнд ажлын байраа цөөлнө. Ажилгүй болсон эсвэл иргэдийн бодит орлого буурах тохиолдолд иргэдийн авсан зээлийн эрсдэл нэмэгдэх болно. Иймд иргэдийн зээлийн дээд хугацааг 30 сар болгосон.

### **ЭНЭ ШИЙДВЭР ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДАД ХЭРХЭН НӨЛӨӨЛӨХ ВЭ?**

Зарим ААНБ-д богино хугацаанд нөлөөлж болзошгүй. Тухайлбал шинэ, өндөр үнэтэй авто машин импортлогчид байна. Тэд урт хугацааны зээл олгодог учраас энэхүү шийдвэр үйл ажиллагаанд нь нөлөөлнө.

### **БАНКУУДЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ҮЗҮҮЛЭЛТЭД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАН, 30 САР ГЭСЭН ХУГАЦААГ ХЭРЭГЛЭЭНИЙ ЗЭЭЛД ЦААШИД БАЙНГА МӨРДӨХ БОЛЛОО. БАНКУУД ЭНЭ ШИЙДВЭРИЙГ ЯАЖ ХҮЛЭЭЖ АВСАН БЭ?**

Бид банкуудын иргэдийн зээлийн төлөвийг нэг жил гаруй хугацаанд судалж, газар дээр нь шалгалт хийж, нарийвчилсан мэдээлэл цуглуулсан. Хэрэглээний зээл яагаад өсөв, ямар эрсдэл байна гэдгийг судалсан юм. Ингээд иргэдийн зээлд өр орлогын

харьцааг зайлшгүй тогтоох, зээлийн дээд хэмжээг 30 сар болгон тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэхүү шийдвэр нь банкны секторт тодорхой эрсдэл үүсэхээс өмнө, урьдчилан сэргийлэх зорилгоор авч хэрэгжүүлж байгаа макро зохистой бодлогын нэг арга хэмжээ юм. Нэгэнт эрсдэл үүссэний дараа түүнийг шийдвэрлэхэд их хэцүү. Өндөр өртөгтэй, эдийн засагт илүү их хохиролтой. Иргэдийн чанаргүй зээл нэмэгдсэн хойно биш өмнө нь сэргийлэх арга хэмжээ авч байгаа гэсэн үг. Сүүлийн жилүүдэд иргэдийн банкны зээл 40-50 хувиар нэмэгдсэн бол ААНБ-уудад олгосон зээл бараг өсөлтгүй байсан. Сүүлийн арван жилд өрхийн өрийн ДНБ-д эзлэх хувь 2 дахин өссөн. Өрхийн өрийн дарамт нэмэгдэх үзэгдэл манай эдийн засагт шинэ зүйл. Өмнөх хямралын үедүүдэд тохиолдоогүй. Өмнөх хямралын үед өрхүүдийн зээл бага байсан тул хэрэглээгээ багасгах боломж байсан байна. Харин одоо орлогынхоо 70 хувийг зээлд төлж буй өрхийн нэг гишүүн ажилгүй болох эсвэл инфляц, ханшийн нөлөөгөөр орлого нь буурах тохиолдолд наад захын хэрэглээгээ хангахад хүндрэлтэй болж хэрэглээгээ хумих, улмаар эдийн засгийн өсөлтийг сааруулах эрсдэлтэй. Хэрэв иргэдийн орлого буурах, ажлын байраа алдах тохиолдолд иргэн хэрэглээгээ танахаас гадна иргэдийн зээл чанаргүй болох эрсдэлтэй. Энэ эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэдийн хэрэглээний зээлийн хугацаа болон өр,

орлогын харьцааг хязгаарлах шаардлага үүссэн гэж хэлж болно. Өрхийн зээл чанаргүй болох нь цаашлаад нийт эдийн засгийн хүндрэлийг гүнзгийрүүлэх эрсдэлтэйг бид бусад орны түүхээс харсан. Жишээ нь АНУ-д 2008-2009 онд ипотекийн зээлд маш бага эрсдэлтэй гэж үзээд зээлээ үргэлжлүүлэн олгоод байсан. Бага орлоготой өрхүүдэд олгож байсан ипотекийн зээлийн хөтөлбөр бүхэл бүтэн санхүүгийн хямрал болж хувирсан шүү дээ.

### **2019 ОНЫ ЭХНИЙ ӨДРӨӨС ШИНЭ ЗОХИЦУУЛАЛТЫГ МӨРДӨНӨ. ОДОО ЗЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ЭНЭ ЖУРАМ ХАМААРАХ УУ?**

Хамаарахгүй. Шинээр зээл авах, зээлийн нөхцөлөө өөрчлөх иргэдэд хамаатай.

### **ЖИШЭЭ НЬ 24 САРЫН ХУГАЦААТАЙ ЦАЛИНГИЙН ЗЭЭЛ АВСАН ИРГЭН ЗЭЭЛЭЭ СУНГАХ БОЛ ЯАХ ВЭ?**

30 хүртэл сар болгон сунгаж болно.

### **ХЭРЭГЛЭЭНИЙ ЗЭЭЛИЙГ ХЯЗГААРЛАСАН БАС НЭГ ЗОРИЛГО НЬ БИЗНЕСИЙН ЗЭЭЛИЙГ ДЭМЖИХ ЮМ БАЙНА. ИНГЭСНЭЭР ИРЭХ ОНД ЯМАР ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙГ БИЗНЕСИЙН ЗЭЭЛД ЗАРЦУУЛАХ БОЛОМЖ БҮРДЭХ ВЭ?**

Ойролцоогоор 1.3 их наяд төгрөг. Гэхдээ энэ нь багцаа тоо. Учир нь энэхүү тооцоо нь банк болон иргэд энэ бодлогын арга хэмжээнд хэрхэн хариу үйлдэл үзүүлэхээс ихээхэн хамаарна. Дээр дурдсанчлан банкууд хэрэглээний зээл биш, бизнесийн зээл түлхүү



## ХЭРЭГЛЭЭНИЙ ЗЭЭЛИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

- Зээлийн өсөлт энэ оны хоёрдугаар улиралд 17.6 хувьд хүрсэн ч дийлэнхийг хэрэглээний зориулалттай, иргэдийн зээл бүрдүүлсэн.
- 2017 оны гуравдугаар улирлаас хэрэглээний зээл жилийн 40-өөс дээш хувиар өссөн.
- Харин бизнесийн зээл дорвитой өсөөгүй.
- Өрхийн нийт өр өмнөх оны мөн үеэс 20 хувиар өсөж, 10587 тэрбум төгрөгт хүрсэн.
- Энэ нь нийт зээлийн 57 хувийг бүрдүүлнэ.
- Шинээр олгож буй цалингийн зээлийн хугацаа 40 сар байгаа нь иргэдийн өрийн дарамтыг өсгөж байна.

олгосноор олон талын ашигтай. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт өссөнөөр ажлын байр өснө, дагаад иргэдийн орлого ч нэмэгдэнэ. Иргэдийн цалин өсвөл илүү өндөр дүнтэй зээл авч болно. Цаашлаад компаниудын үйлдвэрлэлийг нэмэх, эдийн засгийг өсгөх давуу талтай. Ер нь санхүүгийн бүх эх үүсвэрээ иргэдийн хэрэглээний зээлд зориулах нь тийм зөв сонголт болж чадахгүй. Энэ төрлийн зээлүүд ажлын байр нэмэхгүй, өрийг л өсгөнө. Өмнө нь нийт зээлийн 60 хувь бизнесийн, 40 хувь нь хэрэглээний зээл байсан бол одоо нийт зээлийн 57 хувь иргэдийн зээлд ногдож байна.

Ирэх оноос иргэдийн зээлд эдгээр зохицуулалтуудыш мөрдөж эхлэхээр ББСБ-аас зээл авах иргэдийн тоо өсөх нь.

ББСБ-уудыг Санхүүгийн зохицуулах хороо хариуцдаг учраас Монголбанкны шийдвэр нь зөвхөн банк дагаж мөрддөг. Гэхдээ санхүүгийн системийн эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор энэ талаар СЗХ-ны удирдлагуудтай ярилцахаар төлөвлөж байна. Банкуудын иргэдийн зээлийн хүү ББСБ-ынхаас бага. Тэгэхээр банкны зээлийн эрэлт хэвээр байна. Хүмүүс бага хүүтэй зээл авахыг илүүд үзнэ шүү дээ. Хэрэглээний зээлийн хугацааг 30 сар болгосноор хүү бууруулах боломжийг банкуудад олгоно. Өнөөг хүртэл банкууд хүүний бус аргаар өрсөлдөх хандлага давамгайлж ирсэн. Зээлийн хугацааг уртасгах, өр орлогын

харьцааг нэмэгдүүлэх гэх мэтээр нөхцөлөө өөрчилдөг байсан. Харин одоо хүүгээ бууруулах замаар л харилцагч татах зам руу орлоо.

### ЭНЭ ШИЙДВЭР БАНКУУДЫН АШИГТ АЖИЛЛАГААНД НӨЛӨӨЛӨХ ҮҮ?

Төдийлөн нөлөөлөхгүй. Ашигт ажиллагаагаа хэвийн хадгалахад олон сонголт бий. Тэд бизнесийн зээлээ нэмэгдүүлэх боломжтой. Мөн харилцагчдаа тодорхой түвшинд хадгалж үлдье гэвэл хүүгээ бууруулж болно. Банкуудад богино хугацаанд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй ч нийт эдийн засагтаа урт хугацаанд ямар эерэг нөлөө үзүүлэх талаар би түрүүн тайлбарласан.

### ЯРИЛЦСАНД БАЯРЛАЛАА.

Эх сурвалж: Gogo.mn



# МОНГОЛБАНКНЫ ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРЛААС 2018.09.20

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо есдүгээр сарын 20-ны өдөр хуралдаж, бодлогын хүүг хэвээр хадгалах шийдвэр гаргалаа. Мөн макро зохистой бодлогын хүрээнд өрхийн хэрэглээний зээлийн хугацааг 30 сараас хэтрүүлэхгүй байх, валютын зээлийн эрсдэлийн жинг 150 хувиар тогтоож, шийдвэрийн хэрэгжилтийг 2019 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлүүлэхээр тогтлоо. Мөнгөний бодлогын хорооны шийдвэрийг танилцуулах хэвлэлийн бага хурлын үеэр Монголбанкны удирдлагууд сэтгүүлчдийн асуултад хариулав.

**БЛҮҮМБЭРГ ТВ: ХЭРЭГЛЭЭНИЙ ЗЭЭЛИЙН ХУГАЦААГ 30 САРААР ТОГТООХ, ВАЛЮТЫН ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН ЖИНГ 150 ХУВИАР ТОГТООЖ БАЙГАА ШИЙДВЭРИЙН ТАЛААР ИЛҮҮ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛНА УУ.**

**Мөнгөний бодлогын газрын захирал  
Б.БАЯРДАВАА:**

Өнгөрсөн удаагийн Мөнгөний бодлогын хорооны хурлаар өрхийн хэрэглээний зээлийн өр-орлогын харьцаа 70 хувиас хэтрэхгүй байх шийдвэрийг гаргасан. Үүнийг дагаад банкны системд зээлийн өр орлогын харьцааг өөрчлөхгүйгээр хугацааг сунгах байдлаар өрхийн өрийн дарамтыг нэмэгдүүлэх эрсдэл байгаа учраас Монголбанкны зүгээс хэрэглээний зээлийн хугацааны дээд хязгаарыг 30 сар байхаар тогтоож өгч байгаа. Тэгэхээр өр-орлогын харьцаа болон хугацааны хязгаарлалтууд нь хэрэглээний зээлд нэлээд том нөлөө үзүүлнэ. Эцсийн дүндээ өрхүүд өрийн дарамтад орж, санхүүгийн эмзэг байдал нь нэмэгдэх нөхцөл байдал үүсгэхгүй байхаар ирээдүйг харсан бодлогын арга хэмжээ юм. Үүнээс гадна арилжааны банкууд иргэн, аж ахуйн нэгжид олгож байгаа гадаад валютын зээлийн эрсдэлийн жинг 120 хувь байсныг 150 хувь

болгон нэмэгдүүлж байна. Арилжааны банкууд зээл олгоходоо ханшийн эрсдэлийг удирдах боломжгүй, гадаад валютын орлогогүй иргэн, аж ахуйн нэгжид валютын зээл олгох байдлыг хязгаарлах нөлөөтэй. Ингэснээр иргэд, аж ахуйн нэгжүүд валютын ханшийн хэлбэлзлийн үед ханшаас хамааралтайгаар өрийн дарамтад орох байдлыг хязгаарлах арга хэмжээ юм.

**Монголбанкны Дэд Ерөнхийлөгч  
Б.ЛХАГВАСҮРЭН:**

Ерөнхийдөө арилжааны банкуудын хүүний хэмжээ тодорхой байдаг. Төгрөгөөр зээл авах хүү, валютаар зээл авах хүү хоёр өөр байдаг. Энэ нь валютын хадгаламжийн хүү бага байдагтай холбоотой. Тэгэхээр зээл хүсч байгаа иргэд хүү багатай гэдгээр нь валютын зээл авах сонирхолтой байх нь бий. Гэтэл тухайн иргэн, эсвэл аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа нь валютын орлогогүй бол ханш савлах үед ихээхэн хэмжээний алдагдал хүлээдэг. Та бүхний мэдэж байгаачлан 2016 оны сүүлээр ханш өсөх үед валютаар зээл авсан иргэд шүүхэд хандаад, нэлээд хүнд нөхцөл байдал үүсч байсан. Ийм зүйлийг дахин давтагдуулахгүйн тулд Монголбанк урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч

байгаа юм. Энэ юу гэсэн үг вэ гэхээр арилжааны банк валютаар зээл олгохдоо тухайн иргэн, аж ахуйн нэгж валютын орлогогүй бол эрсдэлийн сангийн хэмжээг өндрөөр байгуулахтай холбоотой чухал ач холбогдолтой заалт байгаа. Хэрэглээний зээлийн хугацааны хязгаарлалтыг 30 сар болгож байгаа нь ипотекийн зээлээс бусад бүх зээлд хамаатай.

**ПАРЛАМЕНТ ТВ: ГВУН НЭМЭГДСЭН БАЙГАА Ч АМ.ДОЛЛАРЫН ХАНШ ӨСЧ БАЙНА. ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТӨД ЮУ НӨЛӨӨЛЖ БАЙНА ВЭ?**

**Монголбанкны Дэд Ерөнхийлөгч  
Б.ЛХАГВАСҮРЭН:**

Эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдсөн зүйл байхгүй. Монголбанкны валютын нөөц хэвээрээ байгаа. Томоохон өр төлбөр төлөх эрэлт хэрэгцээ алга. Монгол Улсын хэмжээнд түлш шатахууны импортын хэмжээ нэмэгдсэн зүйл байхгүй. Дэлхий нийтэд АНУ-ын Засгийн газрын явуулж байгаа бодлого, том гүрнүүдийн хооронд явж байгаа худалдааны сөргөлдөөнөөс болж америк долларын ханш өсөх, үүний эсрэг европын евро, японы иень, хятадын юань зэрэг бусад валютын ханш ам.долларын эсрэг суларч байна. Хөгжиж байгаа орнуудын валют ам.долларын эсрэг гурав орчим хувиар суларсан, хөгжиж байгаа жижиг улсуудынх таван хувиас илүү суларсан гэсэн статистик гарсан. Монгол Улсын хувьд оны эхнээс гурав орчим хувиар суларсан байна. Ерөнхийдөө бидний хувьд дэлхийн чиг хандлагаас зөрөөд үсэрчихсэн зүйл байхгүй. Хоёрдугаарт, валютын нөөц хэвийн эхмжээндээ байгаа үед ханшийн огцом савалгаа байна гэж Монголбанк үзэхгүй байгаа. Дэлхийн том гүрнүүдийн зөрчилдөөнөөс эрсдэл үүсэх магадлал байгаа учир Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны шийдвэрээр хүүг арван хувь дээр байлгах, хянамгай ажиглах, хэрэв эрсдэлтэй зүйл гарах үед бодлогын шийдвэрүүдээ өөрчилнө.

**Нөөцийн удирдлага, санхүүгийн зах  
зээлийн газрын захирал А.ЭНХЖИН:**

Валютын ханшийн өөрчлөлтөд нөлөөлж буй хэд хэдэн хүчин зүйл бий. Нэгдүгээрт, манай улсын эдийн засгийн идэвхжил, гадаад зээлийн эргэн төлөлттэй холбоотой валютын эрэлт нэмэгдсэн хандлага бий.

Оны эхний хагасын байдлаар эдийн засаг 6.3 хувиар, импорт наймдугаар сарын байдлаар өнгөрсөн онтой мөн хугацаанд харьцуулахад 38 хувиар тус тус өссөн. Хоёрдугаарт, энэ оны эхний хагасын байдлаар Засгийн газрын өр, төлбөр, арилжааны банкууд болон бусад төрийн байгууллагуудын гаднаас авсан зээл, хүүгийн төлөлтүүд хийгдсэн. Өнөөдрийн байдлаар Эдийн засгийн харьяат бусаас авсан гадаад зээлийн цэвэр дүн сөрөг 140 сая ам.доллар байгаа. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 520 сая орчим ам.доллараар буурсан үзүүлэлт. Мөн гадаад орчны тодорхойгүй байдал манай ханшид нөлөө үзүүлж байна. АНУ-ын Холбооны нөөцийн банкны бодлогын хүү 2.0%-д хүрч, 2010 оноос хойш хамгийн өндөр түвшинд хүрсэнээр АНУ-руу орох хөрөнгийн урсгал нэмэгдэж, Турк улсын лира ам.долларын эсрэг 38%, Аргентины песо 50%, ОХУ-ын рубль 15%, БНХАУ-ын юань 8%, Солонгос улсын вонн 5% сулраад байна. Нийтдээ дэлхийн 170 орчим улсын 52 хувийнх нь ханш ам.долларын эсрэг суларсан байгаа. Харин төгрөгийн хувьд энэ оны эхнээс авч үзэхэд ам.долларын эсрэг 3.4 хувиар суларсан. Нөгөөтэйгүүр, манай улсын экспортын гол бараа, түүхий эдийн үнэ дэлхийн зах зээл дээр буурч байгаа ч экспортын хэмжээ өндөр түвшинд хэвээр байгаа. Энэ оны эхний найман сарын байдлаар гадаад худалдааны эргэлт 860 сая орчим ам.долларын ашигтай гарсан. Гэхдээ Олон Улсын зах зээлд зэсийн үнийг авч үзэхэд оны эхнээс 15%, алтны үнэ 7.5%-аар буураад байхад манай импортын гол бүтээгдэхүүнүүдийн нэг нефтийн үнэ 20%-аар өсөөд байна.

**МОНГОЛБАНКНААС ВАЛЮТЫН ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТ  
ДЭЭР ЯМАР АРГА ХЭМЖЭЭ АВЧ БАЙНА ВЭ?**

**Нөөцийн удирдлага, санхүүгийн зах  
зээлийн газрын захирал А.ЭНХЖИН:**

Монголбанк дотоодын зах зээл дээр ханшийн огцом хэлбэлзэл үүсэх, эрэлт нийлүүлэлтийн зөрүү үүссэн тохиолдолд тухай бүр нь валютын захад валют нийлүүлэх үйл ажиллагаа хийсээр ирсэн. 2018 оны зургаадугаар сараас хойш нийт 390 орчим сая ам.долларыг валютын захад нийлүүлээд байна. Монголбанкнаас авч хэрэгжүүлсэн энэхүү арга



хэмжээний үр дүнд ам.долларын ханшийн хэлбэлзэл манайтай ижил төстэй эдийн засагтай улс орнуудтай харьцуулахад харьцангуй тогтвортой байгаа гэж Төв банкны зүгээс үзэж байна.

**ӨДРИЙН СОНИН: МОНГОЛБАНК ХАНШИЙН ОГЦОМ ХЭЛБЭЛЗЭЛ ДЭЭР ОРОЛЦОНО ГЭЖ БАЙГАА. ХЭДИЙ ХЭМЖЭЭНИЙ ӨӨРЧЛӨЛТИЙГ ОГЦОМ ХЭЛБЭЛЗЭЛ ГЭХ ВЭ?**

Төв банкнаас долоо хоног бүрийн мягмар, пүрэв гарагт валютын дуудлага худалдаа зохион байгуулдаг. Дуудлага худалдаатай өдөр зах дээрх нөхцөл байдлыг ажиглаж хэдий хэмжээний валютын дутагдал үүсч болзошгүй болохыг тооцож, үүн дээрээ үндэслэн Монголбанкнаас валютын захад оролцох эсэхээ шийддэг. Энэ оны хувьд ханшийн нэг өдрийн хэлбэлзэл хамгийн өндөртөө 0.6 хувиар сулрах эсвэл 0.2 хувиар чангарах гэсэн хэлбэлзэлтэй байлаа. Энэ нь Монголбанкны хувьд огцом хэлбэлзэл гэж үзэхээргүй нөхцөл байдал. Дахин хэлэхэд хөрш хоёр орны хувьд гэхэд ОХУ-ын рублийн ханш ам.долларын эсрэг 15 хувиар, Хятадын юань 8 орчим хувиар сулраад байхад Монгол төгрөгийн ханш 3 орчим хувиар суларсан нь муу үзүүлэлт гэж үзэхгүй байна. Мөн гадаад валютын нөөцийн хэмжээ 2.9 тэрбум ам.доллар байгаа. Энэ оны эхний хагаст зээлийн эргэн төлөлт нэлээд хийгдсэн. 2020 он хүртэл томоохон гадаад өр, төлбөр төлөгдөхгүй. Гадаад орчны тодорхойгүй байдлууд үүсээд байгаа хэдий ч, манай улсын экспортын хэмжээ буурахгүй нүүрсний үнэ энэ түвшиндээ хадгалагдаад үлдэх юм бол ханш дунд, урт хугацаандаа огцом хэлбэлзэл үүсэх нөхцөл харагдахгүй байгаа. Гэхдээ гадаад орчин тодорхойгүй, эрсдэл үүсч болзошгүй байгаа учир үүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор Мөнгөний бодлогын хорооны хурлаар валютын зээл болон өр, орлогын харьцаан дээр хязгаарлалтууд хийх шийдвэрүүдийг гаргасан болно.

**НТҮ: МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС ГАДААД ӨР ЗЭЭЛҮҮДИЙН ТӨЛБӨРИЙГ ТӨЛСӨН БАЙГАА. ЭДГЭЭР НЬ ВАЛЮТЫН НӨӨЦ, ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ӨӨРЧЛӨЛТ ҮҮСГЭСЭН ҮҮ?**

**Мөнгөний бодлогын газрын захирал  
Б.БАЯРДАВАА:**

Валютын ханштай холбоотой асуудал дээр нэмэлт

тайлбар өгье. Төлбөрийн тэнцэл оны эхнээс гүйцэтгэл алдагдалтай байгаа. Алдагдалтай байна гэдэг бол Монгол Улсаас цэвэр дүнгээрээ ам.долларын урсгал гарсан гэсэн үг. Хамгийн том нөлөө үзүүлж байгаа хүчин зүйл нь нэгдүгээрт, он гарснаас хойш Чингис бондын үлдэгдэл төлбөр болох 125 сая ам.доллар, Дим сан бондын 145 сая ам.доллар нийт 270 сая ам.долларын төлбөр төлсөн нь гарах урсгалд нөлөөлсөн. Энэ нь валютын зах дээр эрэлт, нийлүүлэлт талаасаа том эрэлттэй байсан гэсэн үг. Хоёрдугаарт, биднээс хамаарахгүй гадаад хүчин зүйл бол улс орнуудын хооронд явагдаж байгаа худалдааны маргаан, Холбооны нөөцийн банкнаас авч хэрэгжүүлж байгаа бодлогын арга хэмжээ зэрэг нь хөгжиж буй орнуудад хүчтэй нөлөө үзүүлж байна.

Үүнтэй уялдуулаад зарим улс орон бодлогын хүүгээ өсгөх, ханшаа сулруулах арга хэмжээнүүд авч байна. Хятад улс үүний эсрэг хүчтэй арга хэмжээ авч юанийн ханшийг нэлээд хэмжээгээр сулруулсан. Мөн ОХУ, Солонгос зэрэг улс орон мөн ханшаа сулруулсан. Энэ нь эргээд гадаад худалдаан дээр үнийн өрсөлдөх чадвараа алдахгүй байх арга хэмжээ авч байна гэсэн үг. Хэдийгээр төгрөг ам.долларын эсрэг суларсан ч, Солонгосын вонн, ОХУ-ын рубль, Хятадын юанийн эсрэг чангарсан. Нэг талдаа юун дээр нөлөөлж байна гэхээр, эдгээр улсаас Монгол Улсад орж ирж байгаа импортын бараа бүтээгдэхүүнүүд ижил төрлийн бараа үйлдвэрлэгч дотоодын үнэтэй өрсөлдөх чадвараа алдах сөрөг нөлөөтэй. Энэ тал дээр тодорхой хэмжээний ханшийн сулралтыг хүлээн зөвшөөрөхөөс өөр арга байхгүй. Эдгээр бизнесийн үнийн өрсөлдөөнийг хадгалж үлдэхийн тулд юм. Иймд ханш тодорхой хэмжээнд сулрахыг Монголбанкнаас нэг талаасаа зөвшөөрч байгаа гэж ойлгож болно. Цаашлаад ханшийн сулралт нь эргээд дунд хугацаандаа эдийн засаг хэт их савлахгүй байх, ханшийн сулрах дарамт хуримтлагдахгүй байхтай холбоотой. Монгол Улсын эдийн засаг түүхий эдийн үнэ, олон улсын зах зээл дэх эрдэс бүтээгдэхүүний үнээс хамааралтай байдал өндөр хэвээр байгаа. Тэгэхээр, энэ орчимд бид эрсдэлийг хуримтлуулахгүй авч явах нь хамгийн чухал. Хоёрдугаарт, эрсдэлийг хуримтлуулахгүй байхын зэрэгцээ аж ахуйн нэгж, өрхүүд, банкны түвшинд хэт их зээлийн дарамтад

орохгүй байх ёстой. Өсөлт цаашаа бизнесийн тэлэлтийн хурдыг тааруулах ёстой. Богино хугацаанд тэлээд уналтад хүрэх эрсдэлээс зайлс хийж байх ёстой. Ийм учраас энэ нь цаанаа юуг хэлж байна гэхээр гадаад эдийн засгийн орчинтой дотоод эдийн засгийн өсөлтийн хурдыг баланслуулж авч явах ёстой гэсэн үг. Төв банкны зүгээс ханшийг интервенц хийгээд бууруулж болно, эсрэгээрээ чангаруулж ч болно. Тэр нь сайн бодлогын сонголт биш юм. Тодорхой хэмжээнд гаднаас орж ирж байгаа зэс, алтны үнэ буурч, нефтийн үнэ өсөж байгааг ханшин дээр тодорхой хэмжээнд шингээж авч явах ёстой. Тэгж байж эрсдэлийг хуримтлуулахгүй бага багаар шингээж, эргээд санхүүгийн тогтвортой байдал, макро тогтвортой байдалд дунд хугацаандаа эерэг нөлөөтэй.

#### **Монголбанкны Ерөнхий эдийн засагч- Ерөнхийлөгчийн зөвлөх Ж.ГАНБААТАР:**

Монголбанк болон төрийн байгууллагуудын хувьд ханшийн хөдөлгөөнөөс гадна голлон анхаарч үзэх ёстой зүйл бол Монгол Улсын өрийн хэмжээ хэд байна вэ, гадаад худалдааны тэнцэл, үйлчилгээний тэнцэл, санхүүгийн тэнцэл нь хэд вэ, хэдий хэмжээний хөрөнгө оруулалтууд ойрын жилүүдэд хийгдэхээр байна зэрэг маш олон зүйлийг харгалзан үзэж дунд, урт хугацааны төлөвөө харж, гадаад валютын нөөцийн хэмжээг бодолцож байх хэрэгтэй. ГВАН нэмэгдээд гурав орчим тэрбум ам.долларт хүрсэн хэдий ч том дүр зургаа харах шаардлагатай. Мэдээж зах дээр огцом хэлбэлзэл гарахад Монголбанк арга хэмжээ авахад бэлэн.

**БАНКИЙГ ДАХИН ХӨРӨНГӨЖҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ ЗӨВХӨН ХОЁР БАНКИНД ЗОРИУЛАГДСАН ГЭХ ШҮҮМЖЛЭЛ, ХАРДЛАГА БИЙ БОЛООД БАЙНА. ЭНЭ ТАЛААР ТАЙЛБАР ӨГНӨ ҮҮ. ХОЁРДУГААРТ, ХУУЛИЙН ДАГУУ БАНКУУДАД ӨӨРИЙН ХӨРӨНГӨӨ НЭМЭГДҮҮЛЭХ ХУГАЦАА ОЛГОСОН.**

#### **ТЭГЭХЭЭР ӨӨРИЙН ХӨРӨНГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦ ЯМАР ХЭМЖЭЭНД БАЙНА ВЭ?**


##### **Монголбанкны Дэд Ерөнхийлөгч Б.ЛХАГВАСҮРЭН:**

Монгол Улсын Засгийн газар ОУВС-тай хамтраад өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр хэрэгжүүлж байгаа. Хөтөлбөрийн хүрээнд бид активын чанарын үнэлгээг банкууддаа хийсэн. Үүгээр 500 орчим тэрбум төгрөгөөр өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн үр дүн гарсан. Энэ оны төгсгөл хүртэл өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх төлөвлөгөөг банк тус бүр ирүүлсэн. Энэ төлөвлөгөөний дагуу өөрийн хөрөнгө нэмэгдээд явж байна. Энэ оны эцэс гэхэд 500 орчим тэрбум төгрөгийн өөрийн хөрөнгийн дутагдлыг банкууд бүрдүүлэх боломжтой. Банкууд өөрийн хөрөнгөө хоёр аргаар нэмэгдүүлж болно. Нэгдүгээр зэргийн өөрийн хөрөнгө болон хоёрдугаар зэргийн өөрийн хөрөнгө гэж бий. Нэгдүгээр зэргийн өөрийн хөрөнгө бол дүрмийн сан юм. Дүрмийн санг нэмэгдүүлэхийн тулд одоогийн хувьцаа эзэмшигчид өөрсдөө хөрөнгө оруулалтаа нэмж болно. Эсвэл шинэ хөрөнгө оруулагчийг татаж оруулах арга бий. Хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийн тухайд, 5-аас дээш хугацаатай хадгаламжийг татах байдлаар бүрдүүлж болно. Энэ хоёр аргыг банкууд аль алиныг нь хэрэглэж, ажиллаж байна. Гэхдээ аль нь хэдэн хувь байх вэ гэдгийг Монголбанкны зохистой харьцааны үзүүлэлтээр тогтоодог. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хэмжээ хоёрдугаар зэрэглэлийнхээс 50 хувиар илүү байх ёстой гэх мэтчлэн. Яг энэ харьцааны дагуу л өөрийн хөрөнгөө бүрдүүлэх ёстой. Энэ бүгдийг Монголбанк хянаж байгаа. Хэрвээ банкууд өөрийн хөрөнгөө нэмэгдүүлж чадахгүй бол таны хэлсэнчлэн банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуулийн дагуу арга хэмжээ авах шаардлагатай болно. Гэхдээ Монголбанкны үзэж байгаагаар ийм арга хэмжээг авах шаардлагатай тулсан банк гарч ирэхгүй байх.




## Хадгаламжийн хүү

Зураг 1.1. Нийт шинээр татсан хадгаламж, хүү



## Зээлийн хүү

Зураг 1.2. Нийт шинээр олгосон зээл, хүү



- Иргэдээс татсан ₮-ийн хадгаламжийн ЖДХ 12.7%, хувийн байгууллагаас татсан ₮-ийн хадгаламжийн ЖДХ 10.7%-тай байна.
- Иргэдэд шинээр олгосон ₮-ийн зээлийн ЖДХ 18.7%, хувийн байгууллагад олгосон ₮-ийн зээлийн ЖДХ 17.3%-тай байна.




## Хадгаламжийн хүү

Зураг 1.3. Нийт хадгаламжийн үлдэгдэл, хүү



## Зээлийн хүү

Зураг 1.4. Нийт зээлийн үлдэгдэл, хүү



- Иргэдийн ₮-ийн хадгаламжийн ЖДХ 12.3%, хувийн байгууллагын ₮-ийн хадгаламжийн ЖДХ 11.0%-тай байна.
- Иргэдийн ₮-ийн зээлийн ЖДХ 18.7%, хувийн байгууллагын ₮-ийн зээлийн ЖДХ 15.8%-тай байна.




## Мөнгөний нийлүүлэлт

Зураг 2.1. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн бүтэц



## Зээл

Зураг 2.2. Мөнгөний үзүүлэлтүүдийн сарын өөрчлөлт, тэрбум ₮



- М2 мөнгөний жилийн өсөлт 20.1%-д хүрч 17.4 их наяд ₮ болов.
- Өмнөх сараас 1.3%-иар буюу 229.2 тэрбум ₮-өөр өсөв.
- Үүнээс, М1 мөнгө 4.3% (132.2 тэрбум ₮), бусад хадгаламж 0.7% (97.0 тэрбум ₮) –иар өссөн байна.
  - М1 → ₮-ийн харилцах 120.8 тэрбум ₮-р, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 11.4 тэрбум ₮-р буурав.
  - Бусад хадгаламж → ₮-ийн хадгаламж 54.5 тэрбум ₮-р, \$-ийн харилцах 56.3 тэрбум ₮-р өсч, \$-ийн хадгаламж 13.8 тэрбум ₮-р буурав.






%

ХҮҮ

МӨНГӨ,  
САНХҮҮГИЙН  
СТАТИСТИКИПОТЕКИЙН  
ЗЭЭЛ

## Мөнгөний нийлүүлэлт


Зураг 2.3. Мөнгөний нийлүүлэлтийн бүтэц



- Нийт M2 мөнгөний нийлүүлэлтийн 54.0%-ийг ₮-ийн хадгаламж бүрдүүлж байгаа бол 15.1%-ийг валютын хадгаламж, 14.8%-ийг ₮-ийн харилцах, 12.4%-ийг валютын харилцах, үлдсэн %-ийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө бүрдүүлж байна.
- Нийт хадгаламжийн хэмжээ 12.1 их наяд ₮-т хүрснээс 83.2%-ийг иргэдийн хадгаламж, 16.8%-ийг байгууллагын хадгаламж бүрдүүлж байна.
- Иргэдийн хадгаламжийн 19%-ийг, байгууллагын хадгаламжийн 36.2%-ийг гадаад валютын хадгаламж бүрдүүлж байна.

## Зээл

Зураг 2.4. Нийт хадгаламж




%

ХҮҮ

МӨНГӨ,  
САНХҮҮГИЙН  
СТАТИСТИКИПОТЕКИЙН  
ЗЭЭЛ

## Тайлант сард олгосон зээл

Зураг 3.3. Ипотекийн зээлийн үлдэгдэл санхүүжилтийн эх үүсвэрээр




Ипотекийн зээлийн үлдэгдлийн 75.8% нь хөтөлбөрийн зээл, 21.8% нь банкуудын өөрийн эх үүсвэрээр, 2.3% нь бусад эх үүсвэрээр олгосон зээл эзэлж байна. Харин орон нутгийн ипотекийн зээл\*-ийн 77.4% нь хөтөлбөрийн зээл, 21.7% нь өөрийн эх үүсвэрээр, 0.8 нь бусад эх үүсвэрээр олгогджээ.

\*Уг зээл нь орон нутгийн банкны салбараас олгосон бус худалдан авсан орон сууцны байршилээр тооцсон.

## Зээлийн үлдэгдэл


Зураг 3.4. Ипотекийн зээлийн үлдэгдэл аймгуудаар



## Мөнгөний нийлүүлэлт

Зураг 2.9. Хугацаа хэтэрсэн зээл (салбараар)


Нийт хугацаа хэтэрсэн зээлийн 82.6 хувийг хувийн байгууллагын зээл бүрдүүлжээ.



## Зээл

Зураг 2.10. Чанаргүй зээл (салбараар)

Нийт чанаргүй зээлийн 82.9 %-ийг хувийн байгууллагад олгосон зээл бүрдүүлж байна.





## ЗЭЭЛИЙН ХҮҮГ БУУРУУЛАХ СТРАТЕГИЙН ТОЙМ

Монголбанкнаас улирал бүр эрхлэн гаргадаг "МӨНГӨ-САНХҮҮ-БАЯЛАГ" сэтгүүлийн зургаа дахь дугаараас онцлов.

### ЗЭЭЛИЙН ХҮҮГ БУУРУУЛАХ СТРАТЕГИЙН ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА

Банкны салбарын зээлийн хүү 2000-2012 онд тогтвортой буурч байсан бол сүүлийн зургаан жилд өсөх хандлагатай буюу жигнэсэн дундаж хүү нь жилийн 20 орчим хувьтай байна. Зээлийн хүүний энэ түвшинг бага орлоготой орнуудынхтай харьцуулахад харьцангуй бага түвшинд байгаа боловч Монгол Улсын орлогын ангилал болох дундаас доогуур орлоготой орнуудын дундажтай харьцуулахад 5 нэгж хувь, Зүүн Ази, Номхон Далайн орнуудын дундажтай харьцуулахад 10 гаруй нэгж хувиар өндөр байна. Манай орны эдийн засагт зээлийн хүү нь хөрөнгө оруулалт, бизнес эрхлэлтийг дэмжихүйц түвшинд хүртэл буурахгүй байгааг сүүлийн хориод жилийн турш байнга ярьж, холбогдох бодлогын баримт бичиг гаргаж хэрэгжүүлсэн хэдий ч зээлийн хүү өндөр хэвээр байна. Иймд зээлийн хүүг цаашид хэрхэн бууруулах арга замыг эрэлхийлэх,

бодлого болоод стратегийн хүрээнд ямар арга хэмжээ авах шаардлагатайг тодорхойлох нь чухал байна. Иймд зээлийн хүү буурахад шаардлагатай эдийн засаг, санхүү, эрх зүйн суурь орчны талаар үндэсний нэгдсэн ойлголцлыг бий болгож, бодлогын харилцан уялдааг хангахын тулд энэхүү 2018-2023 оны стратеги, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулсан болно.

#### АЛСЫН ХАРАА

"Зээлийн хүүг бууруулах стратеги • 2018-2023" нь бизнес эрхлэх санхүүгийн таатай орчныг бүрдүүлэх, санхүүгийн салбарын хүртээмжийг нэмэгдүүлэх, эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгох алсын зорилготой юм.

#### ЭРХЭМ ЗОРИЛГО

Энэхүү стратегийн эрхэм зорилго нь зээлийн хүү буурах макро эдийн засгийн орчныг бүрдүүлэх, бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэх (бодлогын хүүний

шилжих сувгийг хүчтэй болгох), арилжааны банкны эрсдэл даах чадвар, үр ашиг, засаглалыг сайжруулахад чиглэсэн үр дүнтэй үйл ажиллагаа явуулах замаар зээлийн хүүг бууруулахад оршино. Энэхүү стратеги амжилттай бүрэн хэрэгжсэнээр 2023 оны төгсгөлд банкны зээлийн жигнэсэн дундаж хүүг адил орлоготой бусад орны түвшинд хүргэх буюу одоогийн түвшнээс 5-7 нэгж хувиар бууруулах зорилт тавьж байна.

#### СТРАТЕГИЙН ЗОРИЛТ

Стратегийн зорилт нь зээлийн хүү буурах макро орчныг бүрдүүлэх, мөнгөний бодлогын хүүний шилжих нөлөөг нэмэгдүүлэх, банкны салбарын эрсдэл даах, үр ашиг, засаглалыг сайжруулахад шаардлагатай эрх зүй, удирдлага, үйл ажиллагааны үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн болно. Энэхүү стратеги нь агуулгын хувьд стратегийн 11 зорилтыг агуулсан дараах үндсэн гурван хэсгээс бүрдэнэ.

**Зээлийн хүү буурах макро эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлэх хүрээнд:**

**ЗОРИЛТ 1.** Инфляцийг тогтвортой, нам түвшинд байлгах — инфляцийн зорилтот түвшинг хангах.

**ЗОРИЛТ 2.** Гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, улсын гадаад өрийн тогтвортой байдлыг хангах.

**ЗОРИЛТ 3.** Төсвийн сахилгыг хангах, макро бодлогын уялдааг сайжруулах.

**ЗОРИЛТ 4.** Эдийн засгийг төрөлжүүлэх, дотоод хуримтлалыг нэмэгдүүлэх.

Мөнгөний бодлогын хүүний хадгаламж, зээлийн хүүнд шилжих нөлөөг сайжруулах хүрээнд:

**ЗОРИЛТ 5.** Бодлогын хүүний коридорыг ашиглан хүүний сувгийн нөлөөг сайжруулах.

**ЗОРИЛТ 6.** Санхүүгийн салбарын долларжилтыг бууруулах.

**ЗОРИЛТ 7.** Санхүүгийн хүчтэй тогтолцоотой болох, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг эрчимжүүлэх.

Арилжааны банкны эрсдэл удирдах чадвар, үр ашиг, засаглалыг сайжруулах хүрээнд:

**ЗОРИЛТ 8.** Зээлийн мэдээллийн сан, зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг өргөжүүлэх.

**ЗОРИЛТ 9.** Зээлийн эрсдэлийг бууруулах чиглэлээр хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох.

**ЗОРИЛТ 10.** Банкны үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх.

**ЗОРИЛТ 11.** Төрийн болон банк, санхүүгийн байгууллагын засаглалыг сайжруулах, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах.

**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХҮҮНД НӨЛӨӨЛЖ БҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ: ЭМПИРИК БАРИМТУУД**

Хадгаламж, зээлийн хүү нь санхүүгийн байгууллагын шийдвэрээс хамаарах хэдий ч энэхүү шийдвэрт зах зээлийн бүтэц, санхүүгийн салбарын хөгжил, дэд бүтцийн хөгжил, хууль, эрх зүйн орчин, санхүү, макро эдийн засгийн тогтвортой байдал, мөнгөний бодлогын үр нөлөөтэй байдал зэрэг олон хүчин зүйл тусгалаа олж байдаг. Эдгээр хүчин зүйл нь улс орнуудад зээлийн хүү яагаад ялгаатай байгааг тайлбарлах учиртай. Манай орны хувьд зээлийн хүү өндөр байгаа нь судлаач, бодлого боловсруулагчдын анхаарлын төвд байж, судалсаар ирсэн нэг гол сэдэв юм. Тухайлбал, Зээл, хадгаламжийн хүүний зөрүүнд: (1) макро эдийн засгийн эрсдэл (инфляци, эдийн засгийн өсөлт, валютын ханш); (2) банк хоорондын захын хүү, түүний хэлбэлзэл; (3) зээлийн эрсдэл буюу чанаргүй зээл; (4) валютын ханшийн эрсдэл; (5) зээл, хадгаламжийн зах зээл дэх төвлөрөл, өрсөлдөөний бүтэц (Herfindahl-ийн индекс, төвлөрлийн харьцаа); (6) санхүүгийн зах зээлийн ерөнхий хөгжил (банкны актив/ДНБ, хөрөнгийн захын үнэлгээ/ДНБ); (7) заавал байлгах нөөцийн хувь; (8) өөрийн хөрөнгийн зохистой харьцааны шалгуур (эрсдэлийг хумих арга хэмжээ); (9) банкны үйл ажиллагааны зардал; (10) банкны хүүний бус цэвэр зардал; (11) орлого оруулдаг активын нийт активд эзлэх хувь; (12) банкны удирдлагын үр чадвар буюу нийт орлого, зардлын харьцаа; (13)

банкны өргөжилтийн үр өгөөж (economy of scale) буюу нэгж зээл, эсвэл хадгаламжид ногдох зардал зэрэг нөлөөлдөг байна (ГанОчир 2006, 2009, 2016). Зээлийн хүүнд нөлөөлөгч макро, микро хүчин зүйл нь яагаад зээлийн хүүг өндөр түвшинд хадгалагдахад нөлөөлж буй суурь хүчин зүйлийг дурдвал:

- Манай орны эдийн засаг гадаад цочролд хэт өртөмтгий;
- Нийлүүлэлтийн хүчин зүйлээс хамаарч инфляци нь тогтворгүй, өндөр байсан;
- Макро эдийн засгийн бодлого нь тогтворгүй, мөчлөг дагаж хэрэгжсэн;
- Гадаад валютын нөөц багатай, улсын өр өндөр түвшинд хүрсэн;
- Санхүүгийн тогтвортой байдал хэврэг байсаар өдийг хүрсэн;
- Санхүүгийн зах зээл дээрх Төв банкны оролцоо хэт их байсан;
- Банкны үйл хөдлөл нь мөчлөг дагасан шинжтэй байсан;
- Дотоод хуримтлал багатайгаас депозитын зах зээл дээрх эх үүсвэрийн төлөөх өрсөлдөөн хүчтэй;
- Санхүүгийн бизнес хийх ерөнхий эрсдэл өндөр;
- Институц, засаглалын чанар сул зэрэг болно.

Иймд зээлийн хүүг бууруулах бодлогын арга хэмжээ нь: (i) хүү буурах макро эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлэх; (ii) бодлогын хүүний хадгаламж, зээлийн хүүнд үзүүлэх нөлөөг сайжруулах; (iii) микро хүчин зүйл буюу арилжааны банкны эрсдэл даах чадвар, үр ашиг, засаглалыг сайжруулах гэсэн ерөнхий гурван том стратегийн зорилтод төвлөрөх нь зүйтэй байна.



## АСУУДЛЫН ГОЛ НЬ ХОЁР УЛС ХУДАЛДААНЫ БОДЛОГОО ХЭЛЭЛЦЭЖ ТОХИРОЛЦОХ НЬ ЧУХАЛ

Чжоу Сяочуань нь Хятадын Ардын Банкны Тэргүүн асан бөгөөд 2002 оноос хойш нийт 16 жилийн турш энэхүү чухал албан тушаалд 3 удаа сонгогдон хашиж байсан. Тэрбээр БНХАУ-ын эдийн засгийн реформыг манлайлж хийсэн эрхмүүдийн нэг бөгөөд дэлхийн тэргүүлэх банкир, бодлого боловсруулагчдын нэг юм. АНУ-ын CNBC телевизээс түүнтэй хийсэн ярилцлагыг хүргэж байна.

**Олон Улсад худалдааны маргааны асуудал хурцадмал болж байгаа энэ цаг үед “Худалдааны дайн” БНХАУ-ын эдийн засагт хэрхэн нөлөөлөхөөр харагдаж байна вэ?**

Бидний тооцоолол, математик загварчлалаас нь харахад “Худалдааны дайн” БНХАУ-ын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөө харьцангуй хязгаарлагдмал юм. Үнэндээ бол сөрөг нөлөөг бид тийм ч их хохирол учруулахааргүй буюу эдийн засагт 0.5 хувиас бага хэмжээний нөлөө үзүүлэхээр тооцоолж байгаа. Нөгөө талаар,

худалдааны маргаан өрнөж байх үед Хятад улс гадаад худалдааны түнш орнуудаа илүү олон болгож, төрөлжүүлэх боломж бүрдэж байна.

Гэхдээ хүмүүс тодорхойгүй байдал буюу эрсдэлд тааламжгүй ханддаг. Тийм ч учраас сөрөг нөлөө хөрөнгийн зах зээл дээр үзэгдэж болох юм. Цаашид юу болохыг мэдэхгүй байх үед аж ахуйн нэгжүүд, хөрөнгө оруулагчид бизнест, компанийн хувьцаанд итгэх итгэл сулрах эрсдэл байгаа. Улмаар энэ нь хөрөнгийн зах зээлд дарамт болж болно. Мөн хүмүүсийн сэтгэл зүй илүү тогтворгүй болох

магадлалтай. Үүнийг Турк, ОХУ зэрэг улсын жишээнээс харж болно. Тиймээс Засгийн газар болон Хятадын ардын банк гэх мэт бодлого тодорхойлогч нар “хамгийн муу нөхцөл байдлын” төлөвлөгөөтэй ажиллах хэрэгтэй.

**Та хамгийн муу нөхцөл байдлын төлөвлөгөө гэж хэллээ. Тэгвэл худалдааны маргаан хэр удаан үргэлжлэх талаарх төсөөлөл, тооцоолол байна уу?**

Математик модель нь өөрөө нарийн тооцоолол хийхэд тустай. Тэгэхээр, тус модель дээр үндэслээд хамгийн муу нөхцөл байдал гэдгийг БНХАУ нь АНУ-

ын зах зээл рүү гаргадаг 500 орчим тэрбум ам.долларын бүх бараа, бүтээгдэхүүний экспортоо зогсоохтой дүйцүүлж ойлгож болох юм. Энэ үед тэдгээр бараа, бүтээгдэхүүнийг хэрхэн хамгийн зохистой харьцаагаар бусад орнууд руу экспортлох вэ гэдгийг тодорхойлох хэрэгтэй.

Нөгөө талаас математик моделиуд нь хүмүүсийн сэтгэл хөдлөл, ялангуяа паникт орох зэргийг загварчилж харуулахдаа маруухан. Жишээлбэл Леман Бродерсийн үйл ажиллагаа хүндэрч, дампуурах үед иргэд паникт орж, энэ нь халдварласаар томоохон доргионыг үүсгэсэн. Энэ үйл явцыг урьдчилж тооцоолох эсвэл шинжлэхэд хүндрэлтэй. БНХАУ-ын хувьд эдийн засаг нь дунджаар жилд 6% өсч байгаа, гадаад валютын нөөц хангалттай өндөр хэмжээнд хүрсэн, мөн валютын ханшийн хөвөгч дэглэмд шилжсэн зэрэг нь гадаад худалдааны маргааныг саармагжуулах, сөрөг нөлөөг бууруулах боломжийг олгож байгаа гэдгийг хэлэх хэрэгтэй.

**Энэ жил БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн хэмжээ ихээхэн багасаад байгаа. Худалдааны маргаан үүнд голлох нөлөөтэй байгаа гэж зарим судлаачид үзэж байна. Энэ үнэн үү, эсвэл өөр хүчин зүйл нөлөөлж байна уу?**

Худалдааны маргаан нь яалт ч үгүй нэг голлох хүчин зүйл нь мөн. Түүнээс гадна санхүүгийн хөшүүрэг буурч байгаад хүмүүс

ихээхэн санаа зовниж байгаа юм. Хятадын эдийн засгийн хөгжлийн стратегид томоохон өөрчлөлт явагдаж байна. Урд нь хотжилт хурдтай явагдаж байсан бол одоо хөгжлийн шинэ чиглэл бий боллоо. Урд нь хөрөнгийн зах зээлийн өсөлт үл хөдлөх хөрөнгийн зах зээл дээр тулгуурлаж байсан бол одоо төрөлжилт явагдаж байна. Хятадын хөгжлийн стратеги нь байгаль орчинд илүү ээлтэй болж байгаа юм. Үл хөдлөх хөрөнгийн салбар нь байгаль орчныг ихээхэн бохирдуулж байсан тул хөгжлийн шинэ стратегийг тодорхойлсноор дотоод хүчин зүйл буюу хөрөнгө оруулагчид барилгын компаниудаас хөрөнгөө татаж байгаагийн улмаас хөрөнгийн зах зээлд агшилт ажиглагдаж байна.

Улс орон болгон өөрийн гэсэн харьцангуй давуу талтай. Хятад Улсын харьцангуй давуу тал бол ажиллах хүчний өртөг бага, инженерүүд олонтойд оршиж байгаа. Тэгэхээр, бидний хувьд үйлдвэрлэлээс гаралтай бараа, бүтээгдэхүүнийг экспортлоход илүү ашигтай юм. Харин АНУ-ын хувьд үйлчилгээний салбар маш сайн хөгжсөн. Тэнд үйлчилгээний чадвар, туршлага өндөр. Ялангуяа санхүү, боловсрол, эрүүл мэндийн салбар сайн хөгжсөн. Тэд БНХАУ-руу чиглэсэн үйлчилгээг экспортлоход илүү давуу боломжтой. Мөн БНХАУ-ын бодлого илүү нээлттэй болсон тул АНУ-аас онгоц, хагас дамжуулагч чип, соё шаш зэрэг

олон төрлийн бүтээгдэхүүнийг их хэмжээгээр худалдаж авах боломжтой. Ингэснээр хоёр улсын худалдаанд шинэ баланс тогтож болно. Гэхдээ ерөнхийдөө бол хоёр талт худалдаанд абсолют тэгш байдлыг бий болгоход хэцүү байдаг нь үнэн.

**АНУ-ын конгресс 10-р сард валютын ханшийн позицгийг авч хэлэлцэнэ. Одоогийн байдлаар зарим хүмүүс тодорхой улсуудыг худалдаанд ашиг олохын тулд мөнгөн тэмдэгтийнхээ ханшийг бууруулах манипуляци хийж байна гэж шүүмжилж байгаа. БНХАУ-ын хувьд тус жагсаалтад багтаагүй ч зарим хүмүүс төрөөс юанийн ханшийг унагах бодлого, арга хэрэгслийг хэрэгжүүлж байна гэж болгоомжилж байгаа. Худалдааны маргаан хүчээ авч байх энэ цаг үед Та валютын ханшийн манипуляци асуудлыг улам хүндрүүлэх нь гэж эмээж байна уу?**

АНУ-ын конгрессоос бусад улс орнуудын ханшийн дэглэмийг шүүмжилж, өөрчлөх зөвлөмж өгөх нь зохимжгүй гэдгийг бид бүгд мэднэ. Мөн асуудал байгаа бол талууд хоорондоо ярилцан, шийдвэрлэх нь чухал. БНХАУ-ын хувьд хөвөгч ханшийн дэглэмд шилжсэнээр валютын ханшийг зах зээл тогтоодог болсон. Өнөөгийн байдлаар Хятадын Ардын банкаас валютын ханшийн дэглэм тогтоох реформыг хийгээд байгаа. Мөн тус банкнаас тодорхой хэмжээний валютыг

зах руу нийлүүлсэн гэдгийг хэлэх хэрэгтэй. Гэхдээ Хятадыг юанийн ханшийг зохиомлоор бууруулж байгаа эсэхийг хэлэлцэх цаг биш гэж би бодож байна. Асуудлын гол нь хоёр улс худалдааны бодлогоо хэлэлцэж тохиролцох нь чухал. АНУ-аас улс орнуудын валютын ханшийн хөдөлгөөнийг анхааралтай ажигладаг. Тэд БНХАУ юанийн ханш дээр манипуляци явуулахгүй байгааг мэдэж байгаа болов уу.

**Ерөнхийлөгч Трамп тарифын бодлого хэрэгжүүлээгүй байсан бол Хятад, Америк улсын худалдаа улам их бие биенээсээ хамааралтай болох байсан уу. Нөгөө талаас Вашингтоноос зарим улс оронд эдийн засгийн хориг тавьж байгаа нь тарифын өөрчлөлтөд нэрмээс болж байгаа юу?**

Эдийн засагчид болон санхүүгийн салбарын хувьд харах юм бол хоёр орон сайн хамтын ажиллагаатай байх нь тустай. Гэвч АНУ зарим улсын эсрэг эдийн засгийн хориг тавьж, тарифаа нэмэгдүүлж байгаа тохиолдолд БНХАУ нь ОХУ болон Европын холбооны улсуудтай харилцаагаа сайжруулж, худалдаагаа өргөтгөхөөс өөр аргагүй. Ингэснээр цаашид хамтдаа дэвшинэ.

АНУ бусад улсын эсрэг санхүү, эдийн засгийн хориг ихээр тавибал энэ нь хөрөнгө оруулагчдыг бусад валют руу хөрвүүлэх магадлалтай. Санхүүгийн хямралын өмнөхөн ч



ам.долларын хувьд ижил нөхцөл байдал үүсч байсан. Тухайн үед бусад валютын хөдөлгөөн нь хөрөнгө оруулалтыг татаж улмаар ам.долларт бага зэрэг асуудал үүсгэж байсан.

Хятадын хувьд хүүг либералчлах бодлого хэрэгжүүлж байгаа. Үйл явц хэр байна вэ?

Миний бодлоор бид хүүг либералчлахад чиглэсэн ажлын дийлэнхийг нь хийгээд байгаа. Бид урд нь өөр өөр эдийн засагт тааруулсан мөнгөний бодлогын үндсэн чиглэл, хадгаламжийн хүү, зээлийн хүүтэй байсан. Бид мөнгөний захад либералчлал явуулж, банк хоорондын зах, бондын зах, зээлийн захад, эцэст нь валютын ханшийн реформыг хийсэн. Тэгэхдээ арилжааны үйл ажиллагаанд эрсдэлийг удирдаж, зээлийн хүүд зүй зохистой шингээх ёстой.

**Та үүнд хяналт тавих хэрэгтэй гэж харж байна уу?**

Бид үүнд зориулж нэмэлт удирдлагыг нэвтрүүлж, хэрэгжүүлэх шаардлага байхгүй. Хөгжиж байгаа зах зээлд зарим санхүүгийн байгууллага бүрэн хөгжөөгүй үед рационал үйл ажиллагаа явсаар байдаг. Тиймээс хэт их өрсөлдөөний үед зарим зохимжгүй арга хэрэгсэл ашиглах аюултай тул энэ тал дээр анхаарах нь зүйн хэрэг.

**Хятадын Ардын банкны хувьд бодлогын хүүний коридорыг бий болгох тал дээр ажиллаж байгаа юм байна. Хэр амжилттай явж байна вэ?**

Хүүний хувьд коридор нь аль хэдийн бий болсон бөгөөд Төв банкнаас жишиг лавлагаа хүүг гаргадаг. Эцсийн үр дүндээ арилжааны банкууд банк хоорондын захад оролцохдоо өөрсдөө хүүг тогтоосон коридор дотор шийддэг.

Валютын ханшийн хувьд бид



өдрийн арилжааны хэлбэлзэлд зориулсан хязгаар тавьж өгсөн байдаг. Энэ нь өнөөдөр нэмэх хасах 2 хувь байгаа. Хоёр хувь гэдэг бол харьцангуй өргөн коридор ч гэлээ миний бодлоор өдрийн арилжааны хэлбэлзэл 2 хувьд хүрэх нөхцөл байдал хэзээ ч үүсэхгүй гэж харж байна. Аз болоход бидний хувьд Турк, Аргентин улсуудад үүссэн шиг асуудал тохиолдохгүй байх гэж найдаж байна.

**Хятадын гадаад мөнгөн тэмдэгт Рэнмэнбигийн хүрээнд бодлого тодорхойлогч нар 7 юанийг 1 ам.доллар байх суурийг тавьж өгсөн. Өөрөөр хэлбэл юань ам.долларын эсрэг огцом унахгүй байх хамгаалалт хийсэн. Энэ үргэлжилсээр байх уу?**

Энэ яриа 2016 оны сүүлээр болсон хүмүүсийн ярианаас үүдэлтэй байх. Олон нийт тухайн үед их цухалдуу, болгоомжилсон байдалтай байсан л даа. Тиймээс хүмүүсийн итгэх итгэлд хүч нэмэхийн тулд 7 гэж том тоо хэрэглэгдсэн. Компьютерийн бинар (хоёрт) эсвэл дэсима

(аравт) системийн хувьд 7 гэдэг бол тэс өөр хэмжигдэхүүн. 7-оос их байх уу, бага байх уу гэхээс илүү энэ нь үргэлжилсэн үйл ажиллагааны нэг хэсэг юм. Зарим хүн эдгээр тоон дээр мэдрэг хандаж, шүүмжилж байгаа ч гэсэн ерөнхий дүр зургаар он гарснаас хойш иргэд илүү тайвширч, энэ зэрэг сэдлүүд буурч байна.

**Хятад улс хөрөнгийн дансаа илүү нээлттэй болгож байгаа. Гэхдээ энэ нээлттэй болох үйл явцын хурд хэр зохимжтой түвшинд байна вэ?**

Үнэндээ бол хөрөнгийн дансыг либералчлах нь чухал үйл явц юм. Бид энэ тал дээр аль хэдийн нэлээд зүйлийг хийгээд байгаа. Гэвч Аргентин болон бусад орныг ажиглаж байхад тухайн улс орны иргэд капиталын хязгаарлалт байх эсэх тал дээр санал зөрөлддөг. Миний туршлагаар бол хямралын үед улс орон тогтвортой байдлаа хангахын тулд тодорхой хэмжээний хөрөнгийн хязгаарлалт тавьж болно. Хямралгүй, хэвийн цаг үед

хөвөгч ханшийн дэглэм нь өөрөө эдийн засагт маш их дэмтэй. Хямралын үед хэрэглэж болох маш олон хэрэгслүүд байгаа.

**Хятадын Ардын Банкнаас мөнгөний бодлогын эсвэл эдийн засгийг идэвхжүүлэх шийдвэр гаргах үед тэдгээр шийдвэрүүд нь зах зээл, эдийн засаг руу хэр амжилттай хөрвөж байгаа тал дээр санаа зовниж байгаа юу?**

Миний бодлоор мөнгөний бодлогын үр нөлөө эдийн засагт хангалттай хүрч байгаа болов уу. Нөгөөтэйгүүр зарим орнуудад мөнгөний бодлогын хэрэгсэл хязгаарлагдмал байдаг. Үүнээс болж мөнгөний бодлогын үр нөлөө иргэдийн амьдралд мэдрэгдэхгүй байснаар, олон нийт мөнгөний бодлогод сөргөөр хандах тохиолдол бий. Хамгийн гол нь мөнгөний бодлогод маш чухал зүйл бол түүний дамжих механизм юм.

**Бидэнд цагаа зориулж ярилцсанд баярлалаа**



# САНХҮҮГИЙН ХЯМРАЛААР ЮУ ӨӨРЧЛӨГДӨВ?

Бид энэ удаагийн дугаартаа саяхан тохиосон үйл явдал гэхээс илүү өнгөрснөөс сургамж авах зорилгоор 10 жилийн хугацаанд дэлхийн санхүүгийн хямралаас ямар боломжийг бий болгосон тухай тоймлон толилуулж байна.

Леман Бродерс нь цагтаа дэлхийд 4 дүгээрт ордог хөрөнгө оруулалтын банк байв. Тус банкныг анх ах дүү гурав Леман 1850 онд Алабама мужийн Монтгомери хотод үүсгэн байгуулж, нийт 158 жил үйл ажиллагаагаа явуулахдаа

банкны гэх тодотголтой бүхэнрүү орж байжээ. 2001 оны 9-р сарын 11-ний өдөр Дэлхийн худалдааны төвд халдлага болох үед тэнд байрлаж байсан төв оффис нь нэрвэгдэж хохирол амсчээ. Ингээд зогссонгүй түүнээс хойш 2008 оны дэлхийн санхүүгийн хямралын шуурганд "хуу хамуулж" дампуурлаа зарлав. Энэ нь даалууны эффектийг үүсгэж АНУ-д 2 их наяд ам.долларын нөхөж баршгүй алдагдлыг үүсгэж, цаашлаад дэлхий нийтийн эдийн засгийг доргиох хямралд

хүргэсэн. Леманы жишээ АНУ-д томоохон анхааруулгыг өгсөн тул дампуурахад хэтэрхий том банкуудыг Засгийн газар нь аварч, улмаар Төв банкууд бодлогын хүүгээ тэг хүртэл буулган, уламжлалт бус мөнгөний бодлого буюу актив худалдан авалтыг эхлүүлсэн байдаг. Ингээд төв банкууд "Эцсийн зээлдүүлэгч"-ийн үүргээс гадна "Эцсийн диллер" хэмээх үүргийг өөр дээрээ авч, мөнгөний болоод хөрөнгийн захыг давхар аварч байсан юм.

Дэлхийн санхүүгийн хямралууд өөр өөрийн гэсэн гарц, сургамжтай. АНУ-ын Холбооны нөөцийн банкаас саяхан санхүүгийн хямралаас үлдсэн Мэйдэн Лэйний гэх багц хөрөнгийг амжилттай борлуулж дууссаныг мэдэгдсэнээр уг хямрал эцэс болсныг давхар тэмдэглэлээ. Хямрал дууссан гэж хэлж болох ч гэлээ өдгөө дэлхийн санхүүгийн тогтолцоо өмнөхөө бодвол тэс өөр болсон. Гэхдээ тогтолцоо өөрчлөгдсөн ч гэсэн хүмүүсийн сэтгэлгээ өөрчлөгдсөн болов уу?

## БОЛОМЖ

Их гүрнүүдэд хямралаас суралцаж, алдаагаа дахин давтахгүйн тулд авч хэрэгжүүлж буй хэд хэдэн бодлогын арга зам бий. Тэдгээрийн нэг гарц нь банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ, эрсдэл даах чадварт томоохон ахиц гарсан явдал байв. Өөрөөр хэлбэл банкны тогтолцооны аюулгүй байдал илүү найдвартай хангагджээ. Банкуудын өөрийн хөрөнгийн хэмжээ, түүнд тавих шаардлага нэмэгдэж, системийн эрсдэл буурсан байна. Энд дан ганц АНУ-ын томоохон банкуудаас гадна активын чанарын үнэлгээ, стресс тестийн тусламжтай Европ, Азийн банкууд хөрвөх чадварын удирдлагыг өндөр түвшинд хүргэсэн байв.

Мөн түүнчлэн санхүүгийн

зуучлал буюу төлбөр тооцооны үйл ажиллагаа илүү найдвартай болж, гүйлгээ зогсох эрсдэлээс давхар хамгаалагдсан хамгаалалттай болсон байна. Санхүүгийн хямрал болох үест банкны тогтолцоонд итгэлцэл үгүй болж, төлбөр тооцоо нэг ёсондоо гэнэт зогссон байдаг. Тиймээс энэ хүндрэлээс сургамж авч дэлхийн төлбөр тооцооны тогтолцоонд үүсч болзошгүй эрсдэлийг хамгийн бага түвшинд хүргэн давхар төлөвлөгөөтэй ажиллах болжээ. Тогтвортой бөгөөд найдвартай зуучлал гэдэг бол санхүүгийн тогтолцооны амин сүнс тул энэ хүрээнд томоохон сургамж авч, дахин давтагдахгүй байх нөхцөл байдлыг бий болгож байна.

Санхүүгийн салбарын хяналт шалгалт дэлхий даяар эрсдэлд суурилсан зарчимд шилжиж, асуудал үүссэний дараа биш үүсэхээс нь өмнө тодорхойлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэвшүүлж байна. Банкуудын ашиг алдагдал нь эрсдэлийг хэр сайн удирдсанаасаа хамаарч тодорхойлогддогийн хувьд эрсдэлийг хэт их өсөхөөс сэргийлэх нь зайлшгүй явдал юм. Энд мөн санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах ойлголт давхар багтаж байгаа. Санхүүгийн хэрэглэгчийг дааж чадах хэмжээнээс нь давуулж зээл олгохгүй байна гэдэг нь нэг талаар зээлдэгчийг болзошгүй эрсдэлээс аварч байгаа гэсэн үг. Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалснаар банк нь ч өөрөө учирж болох эрсдэлийг буруулж байгаа тул Олон Улсад энэ үйл ажиллагаа шинэ түвшинд хүрсэн.

## ХҮНДРЭЛ

Хямралын үр дүнд улс орнууд ихээхэн сургамж авсан ч хараахан шийдвэрлэж чадаагүй хүндрэлүүд оршоор байна. Хэдийгээр дампуурахад хэт том буюу системийн ач холбогдолтой банкуудын эрсдэл даах чадварыг сайжруулсан ч гэсэн тэдгээр банкууд өдгөө улам том болжээ. Энэ нь ялангуяа, АНУ болон Европын банкуудад ажиглагдаж байна. Тухайлбал, актив удирдах үйл ажиллагааны хүрээнд хөрөнгө оруулалтын багцууд нь ихээхэн томорсон аж. Банк том байх тусам эрсдэлийг удирдах ажиллагаа улам бүр ярвигтай болдог. Энд онцолж, төв банкуудын актив худалдан авах ажиллагаа нь банкыг дэмжсэн ч гэлээ цаашид энэ нь эргээд дараагийн хямралд хүргэж болзошгүйг эдийн засагчид анхааруулсаар л байгаа.

Мөн нөгөө талаас жижиг банк том банктай өрсөлдөхөд хүндрэлтэй байдаг тул том тоглогчид цөөнтэй "далайн ус" болох санхүүгийн технологи, цахим мөнгөний бизнест хүч түрэн орж ирж байна. Зарим банк өмнө нь хямралын үед хэзээ ч туршигдаж байгаагүй санхүүгийн технологийг үйл ажиллагааныхаа үндсэн хэрэгсэл болгон сонгож байгаа нь эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Өөр нэг томоохон хүндрэл бол



эрсдэлийг зохицуулалт өндөртэй банкны салбараас холдуулан, сэргийлж байгаа ч тэдгээр эрсдэл нь зохицуулалтгүй санхүүгийн салбарт шингэж байна. Энерги хадгалагдах хуультай зарим талаар ойролцоо буюу эрсдэлийг үгүй хийж чадахгүй ч нэг төлөвөөс нөгөө төлөв рүү, нэг салбараас нөгөө салбар руу шилжүүлж байна. Европын Төв банкны Тэргүүн Марио Драги 9-р сард хийсэн мэдэгдэлдээ макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд банкны салбараас бусад санхүүгийн салбарт, ялангуяа даатгалын салбарт шилжсэн эрсдэлийг бууруулах арга хэрэгслийг хэрэгжүүлнэ гэдгийг дурдсан. Даатгалын салбар нь зохицуулалттай болохоор эрсдэлийг удирдахад харьцангуй боломжтой боловч бусад зохицуулалтгүй үйл ажиллагааг хянаж, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд хүндрэлтэй байдаг. Зээлийн хүүд хязгаар тавих жишээн дээр авч үзэхэд зээлийн хүүг зохицуулалттай үйл ажиллагаанд хянах боломжтой ч, зохицуулалтгүй үйл ажиллагаанд боломж хязгаарлагдмал. Тухайлбал, Монгол Улсад банкны салбарт зээлийн хүүнд хязгаарлалт тавих үед зохицуулалтгүй

ломбард, өдрийн зээлдүүлэгийн үйл ажиллагааг дэмжих аюултай.


Өөр нэг хүндрэл бол дараагийн хямрал нүүрлэхэд өнөөгийн бодлогын арга хэрэгслүүд хязгаарлагдмал болоод байна. Бодлогын хүү "Тэг"-тэй тэнцэж ирэх үед актив худалдан авах ажиллагаа Төв банкуудын балансыг урьд хожид байгаагүйгээр тэлсэн. Нөгөөтэйгүүр улс орнуудын өр өдгөө хямрал болохоос өмнөх үетэй харьцуулахад маш ихээр нэмэгдсэн бөгөөд муугаар бодоход хэрэв дараагийн хямрал тохиолдоход бодлогын арга хэрэгслүүд нь хүчин мөхөсдөхөөр байна.

Эцэст нь дэлхийн санхүүгийн хямралын үр дүнд санхүү эдийн засгийн салбарт улс төржилтийг нэмэгдүүлсэн нь өдгөө багагүй хүндрэлийг үүсгээд байна. Ялангуяа санхүүгийн хямрал оргилдоо хүрсэн он жилүүдээс эхэлж, олон нийтэд таалагдах гэсэн эдийн засгийн үндэслэлгүй тооцоо, явцуу улс төржилт нь олон нийтийн анхаарлыг татаж, саналыг нь ихээр татах болов. Өдгөө дэлхийн томоохон эдийн засгуудад популист улс төрчдийн байр суурь ихээхэн нэмэгдээд

байна гэсэн үг. Эдийн засгийг улс төрөөс салгаж, тусад нь хэлэлцэх нь бараг боломжгүй боловч эдийн засгийг хэт улс төржүүлэх нь өөрөө уршигтай болохыг ямар ч мэргэжлийн эдийн засагчид анхааруулдаг.

Дэлхий дахиныг доргиосон 2008 оны санхүүгийн хямралаас сургамж авч, алдаагаа цаашид боломж болгон өөрчлөн ашиглаж байгаа нь өдгөө тодорхой үр дүнд хүрээд байна. Гэхдээ асуудлыг шийдвэрлээгүй буюу бүрэн шийдвэрлэх боломжгүй үед ямар эрсдэлүүд үүсээд байгааг тооцоолох нь цаашид шийдвэр гаргахад тус дэмтэй юм.

**ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ  
(АМ.ДОЛЛАРААР, 28/ХІ ӨДРИЙН БАЙДЛААР)**





# ВАЛЮТЫН ХАНШ ХЭРХЭН ТОГТДОГ ВЭ?

Монгол Улсын хувьд 1992 он хүртэл тогтмол ханшийн дэглэмтэй байжээ. Харин 1996 онд Төв банкны тухай хууль батлагдсанаар зохицуулалттай хөвөгч ханшийн тогтолцоотой болсон. Өөрөөр хэлбэл валютын ханш эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрээр тодорхойлогддог болсон юм.

1. **ХАНШ = ВАЛЮТЫН ҮНЭ**
2. **ВАЛЮТЫН ҮНИЙГ ЮУ ТОГТООДОГ ВЭ?**
3. **ЭРЭЛТ > НИЙЛҮҮЛЭЛТ → ҮНЭ ӨСНӨ**
4. **ЭРЭЛТ < НИЙЛҮҮЛЭЛТ → ҮНЭ БУУРНА**
5. **ЭРЭЛТ НИЙЛҮҮЛЭЛТГИЙГ ЮУ ШИЙДДЭГ ВЭ? НИЙЛҮҮЛЭЛТ  
= ВАЛЮТЫН ОРОХ УРСГАЛ + ХҮЛЭЭЛТ ЭРЭЛТ = ГАРАХ УРСГАЛ  
+ ХҮЛЭЭЛТ**

## ВАЛЮТЫН ХАНШИД НӨЛӨӨЛДӨГ ХҮЧИН ЗҮЙЛС

Валютын ханшид валютын эрэлт, нийлүүлэлт болон ханшийн талаарх олон нийтийн хүлээлт шууд байдлаар нөлөөлдөг.

### Эрэлтийн хүчин зүйлс

Иргэд, ААН-ийн орлого өссөнөөр тэдгээрийн

худалдан авах чадвар нэмэгдэж тэр хэрээрээ дотоодод болон гадаадад үйлдвэрлэсэн бараа үйлчилгээ худалдан авах эрэлт нэмэгдэнэ.

**Жишээлбэл, гадаадад аялах, шинэ машин, гар утас худалдан авах боломжтой болсноор уг барааны төлбөрт зориулан гадаад валют худалдан авах нь валютын**



### **эрэлтийг үүсгэж буй юм.**

Ижил төрлийн импортын бүтээгдэхүүний үнэ буурснаар дотоодод үйлдвэрлэсэн барааг импортын бараагаар орлуулан валютын эрэлтийг нэмэгдүүлнэ.

Жишээлбэл, импортын гурил, Монголд үйлдвэрлэсэн гурилын аль алийг хэрэглэдэг хүмүүсийн хувьд импортын гурилын үнэ буурахад уг гурил ижил чанартай ч үнийн хувьд дотоодод үйлдвэрлэсэн гурилаас хямд болох тул импортын гурил хэрэглэх хүмүүсийн тоо нэмэгдэнэ. Улмаар уг гурилын хэрэглээ нэмэгдсэн тул тус гурилыг худалдан авахад зарцуулах валютын хэмжээ өөрчлөгдөж байна.

### **Нийлүүлэлтийн хүчин зүйлс**

Нийлүүлэлтэд Монголоос гадагш худалдаж буй экспортын бараа, үйлчилгээний орлого, гадаадын хөрөнгө оруулалт зэрэг Монгол Улсад валютын урсгал оруулах үйл ажиллагаанууд нөлөөлдөг.

**Жишээлбэл, манай улсын хөрөнгө оруулалт, засаглалын тогтолцоо сайн байвал Монголд хөрөнгө оруулах сонирхол нэмэгдэж улмаар энэ нь Монгол Улс руу чиглэх валютын урсгалыг нэмэгдүүлдэг. Хууль, засаглалын цаана хөдөлмөрийн бүтээмж, тухайн улсын өрсөлдөх чадвар гэх мэт зүйлс валютын нийлүүлэлт нэмэгдэхэд дам байдлаар нөлөөлдөг.**

Дээр дурдсан эрэлт болон нийлүүлэлтийн хүчин зүйлсийн нөлөөгөөр валютын ханш нь байнга хэлбэлзэж байдаг байна.

### **Хүлээлт**

Богино хугацаанд валютын ханшийн хөдөлгөөнд эрэлт, нийлүүлэлтийн хүчин зүйлсээс гадна зах зээлд оролцогчдын хүлээлт нөлөөлдөг.


**Жишээлбэл, японоос машин худалдаж авах гэж буй Бат, гадагшаа их сургуулийн төлбөрөө төлөх гэж буй Дорж ойрын хугацаанд ам.долларын ханш буурч, төгрөгийн ханш чангарна гэж бодож байгаа бол Бат, Дорж хоёр гадагш төлөх валютаа өнөөдөр худалдан авахгүй аль болох ам.долларын ханш хямдрахыг хүлээнэ.**

Эсрэгээрээ өөрийн урласан ноолууран хувцсыг Европын зах зээлд нийлүүлдэг Цэцэгээ төгрөгийн ханш чангарна гэж үзэж байгаа бол борлуулалтын орлогоос олсон валютаа цаг алдалгүй худалдан төгрөгт хөрвүүлэхийг бодно.

Энэ мэтчилэн зах зээлд оролцогчдын хүлээлтээс шалтгаалан гадаад валютын эрэлт, нийлүүлэлт өөрчлөгдөж байдаг тул богино хугацаанд валютын ханшид хүлээлтийн хүчин зүйлс нөлөөлдөг. Оновчтой, зөв хүлээлт бүрэлдэхэд зах зээлийн мэдээллийг баттай эх сурвалжаас шуурхай авах, түүнийг боловсруулах чадвар чухал.


## МОНГОЛБАНКНЫ ХУДАЛДАН АВАЛТ

Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ 2018 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар нийт 15.7 тонн байна.



## ВАЛЮТ АРИЛЖААНЫ ЦАХИМ ТАЛБАРЫН АРИЛЖААНЫ ТОЙМ

БХВАЦТ-ыг 2017/4/10-нд нэвтрүүлснээс хойш 2018.09.28-ны хооронд 486,6 сая ам.долларын болон 110.4 сая юанийн нийт 857 удаагийн арилжаа БХВАЦТ-т хийгдээд байна.








МОНГОЛБАНК  
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

ЭХ ОРНЫХОО

# АЛТЫГ ЭРДЭНЭСИЙН САНДАА АЯН

2018.06.04-2018.10.30



[www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn)



[@mongolbank.mn](https://twitter.com/mongolbank.mn)



[Mongolbank.mn](https://www.facebook.com/Mongolbank.mn)



[Mongolbankmn](https://www.youtube.com/Mongolbankmn)